



АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО



АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН
ХОЛБООНЫ 2014 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ХАЯГ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо
6-р хороолол, Их тойруу 68/1 “ЛОГОС” төв 7 давхар
Албан журмын даатгагчдын холбоо

УТАС

+ (976) 7010-1177, 7012-1177, 7000-1040, 7000-1277

ФАКС

+ (976) 7000-1040

ВЕБ ХАЯГ

www.ami.mn

ФЕЙСБҮҮК

www.facebook.com/www.AMI.mn

ХУУДАС



АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ ТАЙЛАНГ ТАНИЛЦУУЛАХ ТОВЧ АГУУЛГА

ГАРЧИГ

Нэг. Ерөнхий танилцуулга

1.1 Танилцуулга..... 5

Хоёр. Үндсэн чиг үүрэгт хамаарах ажил, үүргийн хэрэгжилт

2.1 Даатгалын сангийн чиглэлээр..... 7

1. Орлого төвлөрүүлэх, нөхөн төлбөр олгох талаар..... 7

2. Даатгалын баталгаа..... 14

3. Орон нутгийн салбарын ажил, үр дүн..... 18

2.2 Шуурхай албаны талаар..... 20

2.3 Мэдээллийн сангийн програм хангамж, мэдээлэл цуглуулах, лавлагаа олгох ажиллагаа..... 23

2.4 Хууль сурталчилах, даатгалын тохиолдлыг бууруулах сургалт, сурталчилгааны талаар..... 31

1. Хууль хэрэгжүүлэх талаар..... 31

2. Зам тээврийн ослыг бууруулах чиглэлээр..... 32

3. Даатгагч зуучлагч нарыг чадавхжуулах талаар..... 33

2.5 Даатгагчдын үйл ажиллагааны уялдааг хангах, ашиг сонирхлыг хамгаалах-даатгуулагч, хохирогчийн эрх ашиг хамгаалах..... 34

2.6 Дотоод ажил, зохион байгуулалтын талаар..... 35

1. Эрх зүйн хүрээнд боловсронгуй болгох ажлын талаар..... 35

2. Үйл ажиллагааны санхүүжилт, бүртгэл тооцооны талаар..... 36

3. Гадаад хамтын ажиллагааны талаар..... 39

Гурав. Дүгнэлт, санал


НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

Улсын их хурал 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Жолоочийн даатгалын тухай хууль баталж, Санхүүгийн зохицуулах хороо 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 301 дугаар тогтоолоор Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж, мөн оны 11 сарын 07-ны өдөр Албан журмын даатгагчдын холбоо (ТББ)-г үүсгэн байгуулжээ. Тус холбооны үйл ажиллагааны чиглэл, эрх үүргийг хуулиар тодорхойлсон байна. Холбоо нь даатгалын санг бүрдүүлж, нөхөн төлбөр олгох, даатгалын сангийн дуудлага хүлээн авч үйлчлэх шуурхай албыг зохион байгуулах, жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, албан журмын даатгалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй даатгагчдын үйл ажиллагаа, уялдаа холбоог ханган зохион байгуулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх сурталчилгаа хийх, даатгагч, хохирогчийн эрхийг хамгаалах үүрэгтэй ашгийн төлөө бус хуулийн этгээд юм.

Санхүүгийн зохицуулах хороо нь Холбооны үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам зааврыг баталж, уг Холбооны үйл ажиллагаанд хяналт тавина. Холбоо нь хууль тогтоомжид нийцсэн Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн дүрэмтэй. Хорооноос томилсон удирдах зөвлөлтэй, удирдах зөвлөлөөс томилсон гүйцэтгэх захирал гүйцэтгэх удирлагыг хангаж байна. Албан журмын даатгагчдын холбоо ТББ дараах удирдлагын бүтэц зохион байгуулалтаар үйл ажиллагаа явуулж байна.

График №1. Холбооны удирдлагын бүтэц, зохион байгуулалт



Санхүүгийн зохицуулах хорооноос 2014 онд Холбооны үйл ажиллагаанд шалгалт хийж, хуулийн хэрэгжилтээр даатгалын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж дүгнэлт гаргасан байгаа. Энэ дүгнэлтээр манай холбооны бүтцэд анхаарах шаардлага тавьсаныг шинэ бүтэц батлахдаа авч үзэж хуулийн дагуу явах нь зүйтэй юм. Шуурхай албыг өөрчлөн зохион байгуулах, сургалт судалгаа, сурталчилгааны хэлтсийг татан буулгах бусад нэгжид үүргийг нь шилжүүлэх гэх мэт.

Холбоо нь удирдах зөвлөлөөс баталсан 2016 он хүртэл баримтлах стратеги төлөвлөгөөтэй бөгөөд түүнийг хэрэгжүүлэх ажлыг жил жилийн төлөвлөгөөнд тусгаж, үр дүнг тооцон ажиллаж байна. Холбоо тайлант хугацаанд Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль болон Холбооны дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллалаа.

Холбооны Удирдах зөвлөл тайлант хугацаанд 7 удаа 63.2 хувийн дундаж ирцтэйгээр хуралдаж нийт 31 асуудал хэлэлцэн 19 тогтоол, тэмдэглэлээр 23 шийдвэр гаргажээ. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанд 2 асуудал оруулж хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Гүйцэтгэх захирал нийт 152 тушаал гаргаж ажлын албаны үйл ажиллагааг чиглүүлэн ажиллажээ.

Хүснэгт №1. Удирдах зөвлөлийн ажлын үзүүлэлт

д/д		2012 он	2013 он	2014 он
1	Хуралдааны тоо	23	11	7
2	Хэлэлцсэн асуудлын тоо	76	38	31
3	Тогтоол	49	21	19
4	Хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг	79	36	23
5	Хуралдааны үргэлжилсэн хугацаа	46 цаг 22 мин	20 цаг 55 мин	15 цаг 03 мин

Удирдах зөвлөлийн 2014 онд гаргасан шийдвэрийн хэрэгжилт 97.6 хувьтай байна. Жолоочийн даатгалын тухай хуулийн 28.1.1-д заасан торгуулийн орлогыг санд төвлөрүүлэх үүрэг хагас биелэлттэй байна. Тайлант хугацаанд Холбооны нийт бичиг хэргийн эргэлт 1269, үүнээс албан байгууллага, иргэдээс 514 албан бичиг, өргөдөл, гомдол нийт 169-ыг хүлээн авч, байгууллага, иргэдэд нийт 514 албан бичиг явуулсан байна.

Холбоо жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам заавруудыг боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулахад санал өгч, ажлын хэсэгт орж ажилласан ба жолоочийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой 2 журам, заавар, аргачлал шинээр боловсруулан, 8 журам, зааварт өөрчлөлт оруулах санал боловсруулж хороонд хүргүүлжээ.

Даатгалын тухай хуулийн 12¹.1-д албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь Холбооны гишүүн байна гэж заасан. Монгол улсад албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгалын 16 компани, орон нутагт даатгалын компанийн 213 салбар, даатгалын 2357 төлөөлөгч ажиллаж байна. Холбоо нь жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд яам, агентлаг, аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар даатгалын мэргэжлийн оролцогчидтай хамтран ажиллалаа.

ХОЁР: ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖИЛ, ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

2.1 ДААТГАЛЫН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Жолоочийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт

Монгол улсын Их хурлаас 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр баталсан “Жолоочийн даатгалын тухай хууль”-ийн тавдугаар бүлгийн 22.1-д Жолоочийн даатгалын санг үндсэн 6 төрлийн эх үүсвэрээр бүрдүүлэхээр хуульчлагдсан. Үүний дагуу Даатгалын сангийн орлого төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж байна. Санхүүгийн зохицуулах хороо, аймаг нийслэлийн Санхүү төрийн сангийн хэлтэс, даатгалын компаниуд болон бусад байгууллагуудтай хамтран ажилласаны дүнд даатгалын санд 2014 онд 3,171,292.6 мян. төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 100.1 хувиар биелүүлэв.

Хүснэгт №2. Даатгалын сангийн 2014 оны орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл

д/д	Орлогын төрөл	2012 оны гүйцэтгэл	2013 оны гүйцэтгэл	2014 оны	
				төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Авто тээврийн болон өрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувь /АТБӨЯХАТ/	-	2,290,996.6	2,704,000.0	2,682,136.2
2	Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагчдаас төвлөрүүлэх хөрөнгө	340,000.0	473,739.0	420,000.0	459,448.4
3	Жолоочийн даатгалын хууль тогтоомжийн зөрчилд ногдуулсан торгуулийн орлого	-	-	40,000.0	2,208.0
4	Мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсны орлого	-	3,000.0	5,000.0	27,500.0
5	Зээл, тусламж, хандив, бусад орлого	-	-	-	54,042.7
6	Нөхөн төлбөрийн буцаан төлөлтийн орлого	-	9,725.6	30,818.5	60,651.9
7	Сангийн менежментийн үр дүн	7,814.2	23,767.0	180,000.0	223,462.3
Орлогын нийт дүн		347,814.2	2,801,228.2	3,379,818.5	3,509,517.5

Даатгалгүй этгээд хууль зөрчин замын хөдөлгөөнд оролцохдоо бусдад учруулсан хохирлыг арилгаж, түүнийг буруутай этгээдээс буцаан нэхэмжилж авах замаар нөхөн төлбөрийн буцаан төлөлтийг төвлөрүүлж хуульд заасны дагуу сангийн орлого болж нөөц санг нэмэгдүүлдэг болно. Энэ ажил цаашдаа ихээхэн хүндэрч болзошгүйг тухайн бүлэгт гарах болно. Мөн НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн бичил даатгалын төслийн орон нутаг дахь сурталчилгааны 4 төвийн тоног төхөөрөмж болох 54.0 сая төгрөгийн хөрөнгийг тусламжийн орлогоор авсан болно.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан нөхөн төлбөрийг олгох зорилгоор даатгалын сангийн тухайн жилийн зардлаас давсан орлогын үлдэгдлийг Санхүүгийн зохицуулах хорооны баталсан журмын дагуу банкинд хадгаламж, сертификат хэлбэрээр байршуулж олсон хүүгийн орлогыг даатгалын санг нэмэгдүүлэх нэг эх үүсвэр болгов.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.1 заалтын дагуу албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагч бүрээс төвлөрүүлэх хөрөнгө 459.4 сая төгрөг оров.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.2-д заасан этгээдэд хуулийн дагуу ногдуулах торгуулийн орлогын 50 хувийг бүрдүүлэх ажлын хүрээнд Замын цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж хяналт шалгалтыг тогтмол явуулсаны үр дүнд зөрчил бүхий 1658 иргэд, байгууллагад 318.3 сая төгрөгийн торгууль ногдуулж орон нутгийн төсөвт оруулав.

Тухайлбал: Улаанбаатар хотод 1577 торгуулийн хуудсаар 278.2 сая төгрөг, Баян-Өлгий аймагт 2 иргэн 384.0 төгрөг, Говьсүмбэр, Дорноговь аймагт 3 иргэн 576.0 төгрөг, Өвөрхангай аймагт 8 иргэн 1.5 сая төгрөг, Өмнөговь аймагт 10 иргэн 1.9 сая төгрөг, Төв аймагт 5 иргэн 960.0 мянган төгрөг, Хөвсгөл аймагт 11 иргэн 2.1 сая төгрөг, Хэнтий аймагт 7 иргэн 1.7 сая төгрөгийн торгууль төлсөн байна.

Гэвч Холбооны даатгалын санд Баян-Өлгий аймаг 192.0 мянган төгрөг, Говьсүмбэр аймаг 672.0 мянган төгрөг, Хөвсгөл аймаг 1.056 сая төгрөг, Хэнтий аймаг 672.0 мянган төгрөг нийт 2,208.0 мян.төгрөгийн торгуулийн орлого анх удаа төвлөрүүлсэн нь Холбооны аймаг орон нутгийн салбарын үйл ажиллагааны үр дүн буюу Жолоочийн даатгалын тухай хуулийг орон нутгийн удирдлагууд дэмжин ажиллаж, хэрэгжүүлж эхлээд байгаагийн илрэл юм.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.3 дахь заалтын дагуу буцаан нэхэмжилсэн нөхөн төлбөрөөр нийт 60.6 сая төгрөг төвлөрүүлсэн бөгөөд үүнээс 2013 онд олгогдсон нөхөн төлбөрийн буцаан төлөлт 23.7 сая төгрөг эргэн төлөгдөж, 16.9 сая төгрөгийг хугацаанд нь төвлөрүүлж чадаагүй байна.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан үндэслэлийн дагуу 2014 онд 64 даатгалын тохиолдлын хохирогчид нөхөн төлбөр олгосон бөгөөд үүнээс 36.9 сая төгрөгийн эргэн төлөлт хуваарийн дагуу нэхэмжлэн авлаа.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.4 дэх заалт буюу автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувийг Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэхээр хуульчлагдсаны дагуу 2,682,136.2 мян.төгрөг төвлөрүүлж 99.2 хувийн биелэлтэй байна.

Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн татварын 10 хувийг, Говь-Алтай, Өмнөговь аймаг 28,257.2 мян.төгрөгөөр тасалдуулсаныг жинхэнэ гүйцэтгэлээр нь тооцож үзэх шаардлагатай байгаа юм. Дундговь, Ховд аймаг 5,193.0 мян.төгрөгөөр давуулж биелүүлэв.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.5 дахь заалт болох мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсанаар 24.5 сая төгрөг төвлөрсөн байна.

Жолоочийн даатгалын сангийн МИИС системийг ашиглах тухай гэрээг даатгалын зуучлагч “Эрсдлийн шийдэл” ХХК, “Сүрэг хараацай” ХХК, “Лоялти солюшн” ХХК, ХААН банк, Төрийн банк, Капитал банк, “Гэрэлт буян ундрах” ХХК, “Ачит-Ундарга” ХХК-тай байгуулж ажиллаа. Мөн мөнгөн хөрөнгөөр биш боловч зээл тусламж хандивын хөрөнгийг орлогод авах, сангийн хөрөнгөөс тухайн онд санхүүжүүлж бэлтгэсэн элэгдэл хассан үнээр тооцогдсон үндсэн хөрөнгө, сангийн хөрөнгийг банкинд хадгалуулж олсон хүүгийн орлого нь даатгалын санг аривжуулж байна.

(санхүүгийн тайлангийн тодруулгыг үзнэ үү)

Хүснэгт №3. ДААТГАЛЫН САН БҮРДҮҮЛЭЛТИЙГ АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР АВЧ ҮЗВЭЛ

д/д	Аймаг нийслэл	2014 оны төлөвлөсөн	АТӨЯХ Татварын гүйцэтгэл	Торгуулийн орлого	Будаан нэхэмжилсэн нөхөн төлбөр
1	Улаанбаатар	1,926,610.0	1,926,610.0	-	57,846.622
2	Архангай	19,239.3	19,239.3	-	-
3	Баян-Өлгий	24,346.1	24,346.1	192.0	-
4	Баянхонгор	32,000.0	32,000.0	-	-
5	Булган	24,416.6	21,079.5	-	-
6	Говь-Алтай	33,221.0	20,661.03	-	824.000
7	Говьсүмбэр	8,907.1	8,907.1	288.0	-
8	Дархан-Уул	44,939.3	44,939.3	-	346.250
9	Дорноговь	43,347.8	43,347.8	-	-
10	Дорнод	25,500.0	25,500.0	-	-
11	Дундговь	19,001.8	23,298.31	-	-
12	Завхан	19,215.2	19,215.2	-	-
13	Орхон	61,755.8	61,755.8	-	-
14	Өвөрхангай	42,908.46	42,908.5	-	-
15	Өмнөговь	162,360.14	150,000.0	-	-
16	Сүхбаатар	26,500.0	26,500.0	-	-
17	Сэлэнгэ	43,719.0	43,719.0	-	615.000
18	Төв	25,723.7	25,723.7	-	785.000
19	Увс	21,495.8	21,495.8	-	-
20	Ховд	35,390.9	35,287.41	-	-
21	Хөвсгөл	39,531.0	39,531.0	1,056.0	-
22	Хэнтий	23,871.0	23,871.0	672.0	235.000
Нийт дүн		2,704,000.00	2,682,136.25	2,208.0	60,651.872

Жолоочийн даатгалын сангаас хохирогчдод олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх, төвлөрүүлэхэд ихээхэн цаг хугацаа, хөрөнгө зарцуулж байна. Жолоочийн даатгалын тухай хуульд заасаны дагуу даатгалын компаниудад 2012 оны эхнээс, Даатгалын сан 2013 оны эхнээс нөхөн төлбөр олгож эхэлсэн юм.

Албан журмын даатгагчдын холбооны Даатгалын сан нь 2014 онд Жолоочийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу зам тээврийн ослын улмаас учирсан хохирлоо барагдуулахыг хүссэн 109 өргөдөл хүлээн авч нийт 264.7 сая төгрөгийн хохирлын материалыг хянаж судалсан байна.

Даатгалын тухай хуульд заагдсан гишүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж даатгалын компаниудтай нягт хамтран ажилласаны дүнд өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад ирүүлсэн өргөдлийн тоо 11.2 хувиар нэмэгдэж, нөхөн олгосон хохирлын хэмжээ 3.7 дахин өссөн байна.

Иргэд, хувь хүнээс ирүүлсэн өргөдлийн тоо 2.7 дахин нэмэгдсэн нь Холбооноос албан журмын даатгалыг төлөвшүүлэх чиглэлээр хийж байгаа Жолоочийн хариуцлагын даатгал болон даатгалын сангийн талаарх сурталчилгааны ажлын үр дүн гэж үзэж байна. АЖДХ-нд хандсан нөхөн төлбөр олголтыг судалж үзвэл дараах хүснэгтээс байдлыг харж болно.

Хүснэгт №4. Ирүүлсэн өргөдлийн ангилал

д/д	Ангилал	2013 он	2014 он
1	Холбооны салбараас	42	13
2	Даатгалын компаниудаас	23	15
3	Бусад байгууллагаас	7	9
4	Иргэдээс	26	72
Нийт дүн		98	109

Миг даатгал компаниас ирүүлсэн нөхөн төлбөр олгохыг хүссэн 99 өргөдлийг Санхүүгийн зохицуулах хорооноос хянаж үзсэний дагуу даатгалын сангаас хохирлыг барагдуулах хууль эрх зүйн үндэслэлгүй байна гэсэн шийдвэр ирүүлсэн учир нэгдсэн дүн мэдээнд оруулаагүй болно.

Хүснэгт №5. Даатгалын сангаас нөхөн төлбөр хүссэн өргөдлийн хохирлын хэмжээгээр нь ангилан авч үзвэл

д/д	Мөнгөн дүн	2013 он	2014 он
1	500.0 мян хүртэл	53	14
2	700.0 мян хүртэл	6	13
3	1.0 сая хүртэл	5	7
4	1.5 сая хүртэл	8	16
5	2.0 сая хүртэл	7	9
6	3.0 сая хүртэл	5	18
7	4.0 сая хүртэл	6	13
8	5.0 сая хүртэл	5	15
9	5.0 саяас дээш	3	4
Нийт дүн		98	109

Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26 өдрийн 393 дугаар тогтоолоор баталсан “Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар” болон бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд судалж, шаардлагатай нэмэлт материалын бүрдүүлэлт хийсний дүнд 64 өргөдлийн нөхөн төлбөрийг Жолоочийн даатгалын сангаас олгох шийдвэр гарч хохирогчид олгосон байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад шийдвэрлэсэн өргөдлийн тоо 3.4 дахин, олгосон нөхөн төлбөрийн хэмжээ 3.7 дахин өссөн байна.

Холбооны Жолоочийн даатгалын санд ирүүлсэн хохирогчийн өргөдөлд тулгуурлан даатгалын тохиолдол гаргасан буруутай этгээдэд хууль эрх зүй, нөхөн төлбөр олгох болон буцаан нэхэмжлэх журмыг танилцуулсаны дараа буруутай этгээд хохирлыг бүрэн барагдуулсан өргөдөл 2013 онд 48 байсан бол 2014 онд 18 болж буусан нь нийт иргэд байгууллагуудын жолоочийн даатгалын хамрагдалт өссөнийг харуулж байгаа нэг үзүүлэлт юм. Мөн өргөдлийн тоо 2.7 дахин огцом буурсан байхад буруутай этгээдийн барагдуулсан хохирлын хэмжээ 16.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн үнэ өсч байгаа зэрэгтэй холбоотой байх магадлалтай.

Хүснэгт №6. Нөхөн төлбөр хүссэн өргөдөл, шийдвэрлэлт

д/д	Ангилал	2013 он		2014 он	
		тоо	дүн	тоо	дүн
1	Жолоочийн даатгалын сангаас олгосон	19	40,544.132	64	150,724.960
2	Буруутай этгээд барагдуулсан	48	28,353.852	18	44,306.600
3	Олгохоос татгалзсан	26	41,149.520	14	23,145.566
4	Хяналтын явцад байгаа	5	11,203.230	13	27,760.635
Нийт дүн		98	121,633.714	109	245,937.761

Жолоочийн даатгалын сангаас шийдвэрлэсэн нөхөн төлбөрийн хэмжээ нь өмнөх оноос 126.1 сая төгрөгөөр өссөн зам тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрх ашгийн хамгаалах зорилготой Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт нийгэмд зохих хувь нэмрээ оруулж байгаа нэг хэлбэр гэж үзэж байна.

Жолоочийн хариуцлагын Албан журмын даатгалын хуулийг хэрэгжүүлж байгаа нийт даатгалын компанийн дүнгээр нөхөн төлбөрийн мэдээллийг Холбооны мэдээллийн санд нэгтгэсэн дүнг авч үзье.

2014 онд Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 16 даатгалын компани Албан журмын даатгагчдын холбоог оролцуулаад даатгуулагчийн буруугаас болж бусдад хохирол учруулсан 23089 даатгалын тохиолдолд 11,436,191.402 төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Энэ тоог 2013 онтой харьцуулахад зам тээврийн ослын тоо 17.28 хувиар, олгосон нөхөн төлбөрийн хэмжээ 7.4 хувиар тус тус өссөн байна.

Д/д	Даатгагч	Тээврийн хэрэгсэл		Бусад хөрөнгө		Амь нас		Эрүүл мэнд		Нийт даатгалын тохиолдлын тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн нийт дүн
		Даатгалын тохиолдлын тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Даатгалын тохиолдлын тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Даатгалын тохиолдлын тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Даатгалын тохиолдлын тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн		
1	Соёмбо даатгал	995	19,547,594	10	17,421,217	2	10,400,000	7	7,462,775	1014	454,831,586
2	Миг даатгал	2197	1,363,381,689	34	39,432,404	0	-	82	76,933,655	2313	1,479,747,748
3	Мөнх даатгал	114	37,870,843	2	1,148,608	0	-	2	2,246,480	118	41,265,931
4	Монгол даатгал	4735	2,013,723,367	59	60,318,034	9	44,982,876	54	56,464,509	4857	2,175,488,786
5	Практикал даатгал	2061	1,008,259,542	30	43,884,657	1	1,114,600	6	14,699,700	2098	1,067,958,499
6	Гэр даатгал	106	37,636,538	1	266,539	0	-	0	-	107	37,903,077
7	Улаанбаатар хотын даатгал	9	2,289,000	0	-	0	-	0	-	9	2,289,000
8	Номин даатгал	2576	1,068,261,897	20	15,043,766	3	10,105,000	24	19,407,150	2623	1,112,817,813
9	Тэнгэр даатгал	1167	634,349,941	54	52,954,415	1	1,119,529	5	2,161,500	1227	690,585,385
10	Бодь даатгал	3335	1,787,807,784	38	31,098,641	35	59,974,666	34	68,047,978	3442	1,946,929,069
11	Ган зам даатгал	45	26,478,450	0	-	0	-	1	100,000	46	26,578,450
12	Монре даатгал	1420	604,572,497	5	3,397,500	5	11,753,659	6	7,366,480	1436	627,090,136
13	Ард даатгал	2564	1,022,379,718	27	20,775,102	10	43,841,660	52	57,691,571	2653	1,144,688,051
14	Моннис даатгал	5	1,567,600	0	-	0	-	0	-	5	1,567,600
15	Мандал даатгал	706	315,099,730	92	43,465,965	19	6,659,892	19	6,485,900	836	371,711,487
16	Хаан даатгал	241	104,243,724	0	-	0	-	0	-	241	104,243,724
17	АЖДХ	63	146,609,660	0	-	0	-	1	3,885,400	64	150,724,960
Нийт дүн		22,339	10,594,079,574	372	329,206,848	85	189,951,882	293	322,953,098	23,089	11,436,191,402

/төгрөг/

Хохирол барагдуулсан хэмжээг ангилж үзэхэд тээврийн хэрэгсэл, эд хөрөнгөд хохирол учирсан 22337 даатгалын тохиолдолд 10,593.4 сая төгрөгийн нөхөн төлбөр, бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан 379 даатгалын тохиолдолд 512.9 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Эндээс харахад манай хууль хүний амь нас, эрүүл мэндэд анхаарахаас илүү тээврийн хэрэгсэл, эд хөрөнгөд учирсан хохиролд илүүтэй анхаарал хандуулсан байдал харагдаж байгааг цаашид анхаарч үзвэл зохино.

Хүснэгт №8. ХОХИРОГЧДОД ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ АНГИЛЖ ҮЗВЭЛ

д/д	Нэрс	Даатгалын тохиолдлын тоо	Нөхөн төлбөрийн нийт дүн
1	200.000 хүртэлх	8813	1,148,072.379
2	200.000-500.000 хүртэлх	8313	2,581,416.283
3	500.000-800.000 хүртэлх	2461	1,541,471.698
4	800.000-1,000.000 хүртэлх	833	742,985.914
5	1,000.000-1,500.000 хүртэлх	1121	1,367,360.945
6	1,500.000-2,000.000 хүртэлх	488	837,236.583
7	2,000.000-3,000.000 хүртэлх	444	1,070,404.796
8	3,000.000-4,000.000 хүртэлх	188	642,131.595
9	4,000.000-5,000.000 хүртэлх	111	492,283.599
10	5,000.000-8,000.000 хүртэлх	151	811,272.345
11	8,0000000-10,000.000 хүртэлх	9	79,337.704
12	10,000.000	12	122,217.561
Нийт дүн		23.089	11,436,191.402

/төгрөг/

Олгосон нөхөн төлбөрийн 74.6 хувь нь 500.0 мянга хүртэл төгрөгийн хохирол эзэлж байна. Энэ хувь нь өнгөрсөн онд 78 хувьтай байв. Харин 5.0 саяас дээш төгрөгийн нөхөн төлбөрийн хохирол нөхүүлсэн тохиолдлын тоо 2 дахин нэмэгдсэн нь анхаарал татаж байна.

График №9. ХОХИРОГЧДОД ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ТОО ХЭМЖЭЭГ ГРАФИКААР ХАРУУЛБАЛ



Даатгалын тохиолдлын тоог хохирол нөхүүлэх 4 төрлийн ангилалаар нь авч үзэхэд өссөн дүнтэй гарч байгаа учир нь даатгалын 1 тохиолдолд 4 өөр төрөлд хохирол нөхүүлж байгаатай холбоотой болохыг анхаарна уу. 2014 онд нөхөн төлбөр олгогдсон 23089 даатгалын тохиолдолоос 7264 даатгалын тохиолдол нь 2013 онд байгуулагдсан гэрээнээс, 15825 даатгалын тохиолдол нь 2014 онд байгуулагдсан гэрээнд хамаарах нөхөн төлбөр байна.

Хүснэгт №9. ХОХИРОГЧДОД ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨР

/Гэрээ байгуулагдсан оноор/

д/д	Даатгалын гэрээ байгуулагдсан он	2014 онд олгосон нөхөн төлбөрийн тоо	2014 онд олгогдсон нөхөн төлбөрийн дүн
1	2013 онд байгуулагдсан гэрээнээс	7264	4,648,717.660
2	2014 онд байгуулагдсан гэрээнээс	15825	6,787,473.742
Нийт		23.089	11,436,191.402

2. ГЭРЭЭ БАЙГУУЛСНЫГ ГЭРЧЛЭХ ДААТГАЛЫН БАТАЛГААГ ДААТГУУЛАГЧИД ӨГӨХ ҮҮРЭГТЭЙ.

“Жолоочийн даатгалын тухай” хуулийн 8 дугаар зүйл, Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны А274/307 тоот хамтарсан тушаалын дагуу 2014 онд хэрэглэгдэх жолоочийн даатгалын баталгааны загвар батлагдсан.

Тус загвар нь 2013 оны загвар дээр үнэт цаасны дугаарыг QR barcode-оор илэрхийлж 2 талд нь нэмж хэвлэснээрээ онцлогтой юм. Энэ кодыг хэвлэснээр зам дээр хяналт тавьж байгаа замын цагдаагийн байцаагч “Police reader” төхөөрөмжөөр уншиж, тээврийн хэрэгслийн өмчлөгч нь



даатгалтай эсэхийг шалгах боломжийг олгосон. Мөн даатгалын компаниуд даатгалын баталгааны дугаарыг програмд шивэх үйл ажиллагааг хөнгөвчлөх боломжтой болсон юм.

Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2012 оны А/22/23 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Жолоочийн даатгалын баталгааны загварыг хэрэглэх журам”-ын дагуу даатгагч нараас 841300 ширхэг даатгалын баталгааны захиалга авч 1 дүгээр улиралд 99996 ширхэг, 2 дугаар улиралд 299700 ширхэг, 3 дугаар улиралд 190300 ширхэг, 4 дүгээр улиралд 83995 ширхэг нийт 673991 ширхэг наалтыг олгосон байна. Хүснэгт № 10 -д Даатгалын баталгаатай холбоотой тайланг улирал бүр гаргаж Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнаж ажиллаа.

Албан журмын даатгагчдын холбооны жолоочийн хариуцлагын даатгалын МИИС системээр дамжуулан цахим хэлбэрээр мэдээлэл солилцоход бүрэн боломжтой болсон тул даатгалын баталгааны хэвлэмэл хэлбэрийг хүчингүй болгохоор санал оруулсан болно. Манай холбооноос оруулсан санал зөвшөөрөгдвөл даатгагч нарын зардал 100.0 сая орчим төгрөгөөр хэмнэгдэх болно.

Хүснэгт №10. 2014 ОНЫ ДААТГАЛЫН БАТАЛГААНЫ ЗАХИАЛГА, ОЛГОЛТЫН БАЙДАЛ

д/д	Аймаг нийслэл	Ирүүлсэн санал	Хянаж олгосон				Нийт дүн
			I улирал	II улирал	III улирал	IV улирал	
1	Ард даатгал	52.000	7000	25000	17.000	-	49.000
2	Бодь даатгал	180.000	15.000	57.000	25.000	45.000	142.000
3	Ган зам даатгал	1300	100	500	300	-	900
4	Гэр даатгал	22.500	2000	-	-	-	2000
5	Мандал даатгал	30.000	5000	5000	15.000	-	25.000
6	Монгол даатгал	130000	15.000	46.200	31.000	15.000	107.200
7	Монре даатгал	34.000	4900	16.000	8000	8000	36.900
8	Моннис даатгал	500	500	-	-	-	500
9	Миг даатгал	103.000	10.000	45.000	20.000	10500	85.500
10	Мөнх даатгал	4000	2000	-	2000	-	4000
11	Номин даатгал	70.000	12.000	25.000	25.000	-	62.000
12	Соёмбо даатгал	41.000	10.796	15.000	9000	2495	37.291
13	Тэнгэр даатгал	43.000	5000	20.000	15.000	3000	43.000
14	УБ хотын даатгал	11.000	100	1000	5000	-	6100
15	Практикал даатгал	91.500	10.000	30.500	11.500	-	52.000
16	Хаан даатгал	27.500	600	13.500	6500	-	20.600
Нийт дүн		841.300	99.996	299.700	190.300	83.995	673.991

Хүснэгт №11. ДААТГАЛЫН БАТАЛГАА

д/д	Аймаг нийслэл	Даатгалын компаниудаас ирүүлсэн захиалгын санал		Даатгалын сангаас олгосон даатгалын баталгааны тоо		Оны эцэст буцаасан үлдэгдэл /устгалд орох тоо/	
		2013 он	2014 он	2013 он	2014 он	2013 он	2014 он
1	Ард даатгал	42.000	52.000	42.000	49.000	10.012	2978
2	Бодь даатгал	105.000	180.000	105.000	142.000	29.766	48.640
3	Ган зам даатгал	1000	1300	1000	900	784	63
4	Гэр даатгал	6000	22.500	6000	2000	1274	1287
5	Мандал даатгал	15.000	30.000	15.000	25.000	4152	11.830
6	Монгол даатгал	110.000	130.000	110.000	107.200	10.993	14.284
7	Монре даатгал	33.000	34.000	33.000	36.900	12.459	4219
8	Моннис даатгал	600	500	600	500	123	76
9	Миг даатгал	65.000	103.000	65.000	85.500	8.502	-
10	Мөнх даатгал	13.000	4000	13.000	4000	2423	1294
11	Номин даатгал	50.000	70.000	50.000	62.000	6408	10.615
12	Соёмбо даатгал	44.000	41.000	44.000	37.291	11.152	4173
13	Тэнгэр даатгал	45.000	43.000	45.000	43.000	18.991	7546
14	УБ хотын даатгал	1000	11.000	1000	6100	788	5677
15	Практикал даатгал	45.000	91.500	45.000	52.000	11.129	11.833
16	Хаан даатгал	29.000	27.500	29.000	20.600	16.887	7186
Нийт дүн		604.600	841.300	604.600	673.991	145.933	141.401

Тайлбар: Төрийн банкны гэрээтэй даатгалын компаниудаас авсан наалтаас 10350 ширхэг наалт үлдсэн мэдээг холбогдох даатгалын компаниудын дүнд оруулав.

Замын цагдаагийн газартай хийсэн хамтран ажиллах гэрээний дагуу Албан журмын даатгагчдын холбооны мэдээллийн сангаас жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан даатгуулагчдын мэдээллийг солилцдог болсонтой холбогдуулан “Police reader” уншигч төхөөрөмжөөр нийслэлд хяналт тавих бүрэн боломжтой болсон. Харин орон нутагт уг төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй байгааг анхаарах шаардлагатай.

Хүснэгт №12. Жолоочийн хариуцлагын даатгалын баталгааны наалтын тайланг хавсаргав.

Жолоочийн хариуцлагын даатгалын баталгааны наалтын 2014 оны тайлан нэгтгэл

д/д	Даатгалын компанийн нэрс	Холбооноос авсан нийт баталгаа		Бусад даатгачаас шилжүүлэн авсан баталгаа		Гэрээний дагуу даатгуулагчид олгосон баталгаа		Хүчингүй болсон баталгаа		Нохож олгосон		Бусад даатгагчид шилжүүлсэн баталгаа		Үргэлүүлж, дугсан		Эцсийн үлдэгдэл	
		Дугаар /хэдээс хэд хүртэл/	Тоо ширхэг	Дугаар /хэдээс хэд хүртэл/	Тоо ширхэг	Дугаар /хэдээс хэд хүртэл/	Тоо ширхэг	Дугаар /хэдээс хэд хүртэл/	Тоо ширхэг	Дугаар /хэдээс хэд хүртэл/	Тоо ширхэг	Дугаар /хэдээс хэд хүртэл/	Тоо ширхэг	Тоо ширхэг	Тоо ширхэг	Дугаар /хэдээс хэд хүртэл/	Тоо ширхэг
1	Мөнх даатгал	хавсралтаар	4000	хавсралтаар	500	хавсралтаар	1510	хавсралтаар	20	-	-	хавсралтаар	1500	176	хавсралтаар	хавсралтаар	1294
2	Номин даатгал	хавсралтаар	62.000	-	-	хавсралтаар	47.100	хавсралтаар	285	-	-	хавсралтаар	4000	-	хавсралтаар	хавсралтаар	10.615
3	Миг даатгал	хавсралтаар	85.500	хавсралтаар	3990	хавсралтаар	80.563	хавсралтаар	3927	-	-	хавсралтаар	5000	-	хавсралтаар	хавсралтаар	-
4	Соёмбо даатгал	хавсралтаар	37.291	-	-	хавсралтаар	24.874	хавсралтаар	419	-	-	хавсралтаар	6990	835	хавсралтаар	хавсралтаар	4173
5	Ард даатгал	хавсралтаар	49.000	хавсралтаар	1000	хавсралтаар	46.205	хавсралтаар	1428	хавсралтаар	39	-	-	-	хавсралтаар	хавсралтаар	2328
6	Монгол даатгал	хавсралтаар	107.200	-	-	хавсралтаар	90.580	хавсралтаар	2336	-	-	-	-	-	хавсралтаар	хавсралтаар	14.284
7	Моннис даатгал	хавсралтаар	500	-	-	хавсралтаар	406	хавсралтаар	17	хавсралтаар	1	-	-	-	хавсралтаар	хавсралтаар	76
8	Тэнгэр даатгал	хавсралтаар	43.000	-	-	хавсралтаар	34.016	хавсралтаар	369	хавсралтаар	974	-	-	95	хавсралтаар	хавсралтаар	7546
9	Бодь даатгал	хавсралтаар	142.000	-	-	хавсралтаар	88.959	хавсралтаар	3720	хавсралтаар	681	-	-	-	хавсралтаар	хавсралтаар	48.640
10	Монре даатгал	хавсралтаар	36.900	хавсралтаар	500	хавсралтаар	31.634	хавсралтаар	1047	-	-	хавсралтаар	500	-	хавсралтаар	хавсралтаар	4219
11	УБ хотын даатгал	хавсралтаар	6100	-	-	хавсралтаар	288	хавсралтаар	135	-	-	-	-	-	хавсралтаар	хавсралтаар	5677
12	Практикал даатгал	хавсралтаар	52.000	-	-	хавсралтаар	36.577	хавсралтаар	703	хавсралтаар	387	хавсралтаар	2500	-	хавсралтаар	хавсралтаар	11.833
13	Гэр даатгал	хавсралтаар	2.000	-	-	хавсралтаар	646	хавсралтаар	67	-	-	-	-	-	хавсралтаар	хавсралтаар	1287
14	Мандал даатгал	хавсралтаар	25.000	-	-	хавсралтаар	13.168	хавсралтаар	2	-	-	-	-	-	хавсралтаар	хавсралтаар	11.830
15	Ганзам даатгал	хавсралтаар	900	-	-	хавсралтаар	832	хавсралтаар	5	-	-	-	-	-	хавсралтаар	хавсралтаар	63
16	Хаан даатгал	хавсралтаар	20.600	-	-	хавсралтаар	13.054	хавсралтаар	358	хавсралтаар	2	-	-	-	хавсралтаар	хавсралтаар	7186
17	Төрийн банк	-	-	хавсралтаар	15.500	хавсралтаар	3661	хавсралтаар	270	-	-	хавсралтаар	1000	219	хавсралтаар	хавсралтаар	10.350
Нийт дүн		-	673.991	-	21.490	-	514.073	-	15.108	-	2084	-	21.490	1325	-	-	141.401

3. АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ ОРОН НУТАГ ДАХЬ САЛБАРУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ИХЭЭХЭН ХАМААРАЛТАЙ БАЙНА.

Тус Холбооны орон нутаг дахь салбарын 2014 онд хийж гүйцэтгэсэн ажлыг 14 үзүүлэлтээр дүгнэлээ. Ирүүлсэн тайлангаас үзэхэд ихэнх салбаруудын үйл ажиллагаа жигдэрч тухайн орон нутгийн засаг захиргаа, төрийн болон төрийн бус байгууллага, даатгуулагч, иргэдийн дунд Холбооны үйл ажиллагааг болон хуулийн ач холбогдлыг таниулж ажиллаж чадсан байна. Хуулийн ач холбогдлыг орон нутгийн иргэдэд сурталчилахад орон нутгийн Засаг даргын тамгын газар болон холбогдох төрийн байгууллагуудтай нягт хамтран ажилах нь чухал байв. Энэ хүрээнд Баянхонгор, Дархан-Уул, Төв, Увс, Сүхбаатар, Ховд зэрэг ихэнх аймгууд нь хамтын ажиллагааны гэрээ, засаг даргын захирамж, албан даалгавар зэргийг боловсруулан батлуулан ажиллаж зохих дэмжлэг авч чадсан байна.

Холбооны гишүүн даатгалын компаний салбаруудтай хамтран ажиллах, хуулийн хэрэгжилтийн цаг үеийн болон тулгамдаж буй асуудлаар ярилцах, хамтарсан уулзалтыг Баянхонгор, Баян-Өлгий, Хөвсгөл аймаг дахь салбарууд санаачлан сар бүр тогтмол явуулдаг болсон байна. Мөн даатгалын компаний салбарын үйл ажиллагаанд хяналт тавих, заавар зөвлөгөө өгөх талаар өмнөх жилтэй харьцуулахад ахиц гарсан боловч Архангай, Дорнод, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай зэрэг аймгуудад энэ чиглэлээр хангалттай ажиллаж чадаагүй байна. Ялангуяа мэдээллийн сантай холбоотой жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ байгуулах, итгэлцүүрийг зөв хэрэглэж байгаа эсэхэд хангалттай хяналт тавьж ажиллаж чадаагүй байна. Магадгүй салбарын ажилтнуудад шинээр нэвтэрүүлсэн програм хангамжийг ашиглах мэдлэг, дутсан байхыг үгүйсэхгүй.

Зам тээврийн ослоос урьдчилан сэргэмжүүлэх, жолоочийн даатгалын тухай хуулийн ач холбогдлыг орон нутгийн иргэн бүрт хүргэж таниулах нь салбарын ажлын үндсэн үүрэг билээ. Энэ хүрээнд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчилгаа явуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудад сургалт хийж жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулах талаар салбарууд харилцан адилгүй ажилласан байна. Сургалтыг ЕБС сурагчдаас эхлэн замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн жолооч, түүнд хяналт тавьж буй төрийн албан хаагч, удирдлага нарт олон удаагийн давтамжтайгаар сургалтыг зохион байгуулжээ. Ялангуяа Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Төв, Увс, Сүхбаатар, Ховд зэрэг аймаг дахь салбарууд энэ чиглэлд сайн ажилласан байна. Тухайлбал,

Төв аймаг дахь салбар хуулийн ач холбогдол, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн ТВС ТВ-тэй хамтран ажилласан, даатгалын ач холбогдлыг сурталчилсан самбарыг техникийн хяналтын үзлэгийн талбайд байрлуулсан, тайлангийн хугацаанд Жолоочийн даатгалын, Даатгалын тухай болон Зам тээврийн осолгүй ажиллах талаар 2 хэлэлцүүлэг, 9 удаагийн сургалт, 7 ярилцлага, 1 мэдээлэл зохион байгуулж нийт 2123 иргэнийг хамруулсан, Холбооноос гаргасан уриалгыг нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудад хүргүүлж дэмжиж ажиллах уриалга гаргуулж ажилсан, бага ангийн сурагчдад замын хөдөлгөөнд соёлтой, аюулгүй байдлыг хангаж ажиллах таниулах сургалт явуулж Монгол даатгал ХХК-тай хамтран цацруулагчтай цүнх түгээж ажиллажээ.

Баянхонгор аймаг дахь салбар ЗЦТ, АТҮТ-тэй хамтран Хонгор ТВ, ТВ10-ээр мэдээ, мэдээлэл хийх, шууд нэвтрүүлэг явуулсан, сумдын багийн дарга 103 хүнд 2 цагийн сургалт хийсэн, автын үзлэгийн үеэр ТВ10, Гэр бүл ФМ, Баянхонгор ФМ-ээр 1 сарын хугацаатай өдөрт 20 дээш удаа шторк цацсан, ЗЦТ-тай хамтран жолоодлогын тэмцээн зохион байгуулсан, хоорондын ажлын уялдааг хангах хүрээнд аймгийн 22 байгууллагын дунд спортын тэмцээн зохион байгуулсан, Богд, Баянговь, Баян-Өндөр, Галуут сумдад сургалт явуулсан, Аймгйн цагдаагийн газрын нийт 105 албан хаагчид, жолооны курсын сонсогчидод сургалт тус тус явуулжээ.

Дархан-Уул аймаг дахь салбар: Жолоочийн даатгал таныг хамгаална, Эрсдлээ бидэнд даатгаж төгс урагшил, Таны хурд хэтрүүлсэн хором бүхэн хэн нэгний амьдралыг орвонгоор нь өөрчилнө, Согтуугаар жолоо барих аюултай, Хамгаалах бүс таныг хамгаална зэрэг сэдвээр шторкийг хотын төвд байрлалтай Лед дэлгэц, ФМ радиогоор 24 цагийн турш 45 хоног явуулж, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан, Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх тухай олон нийтийн хөдөлгөөн өрнүүлсэн, Хот хоорондын тээвэр эрхэлдэг 6 байгууллагын 23 жолооч нарт сургалт явуулсан, Жолооны сургалтын 2 компаний суралцагч нарт сургалт явуулсан, Нийтийн тээврийн 33 жолоочид сургалт явуулсан, Эрчим хүчний байгууллагуудын 200 ажилтанд сургалт явуулсан, Давж заалдах шатны 15 ажиллагсад сургалт явуулсан, Аймгийн ЗДТГ-ын 35 ажилтанд сургалт явуулсан байна.

Сургалт, сурталчилгааны хүрээнд хийсэн дээрх салбаруудын үйл ажиллагаа нь тухай орон нутгийн иргэд, байгууллагуудад хангалттай хэмжээнд хүрч, даатгалын ач холбогдлыг иргэд талаар хангалттай мэдлэгтэй болсон гэдгийг даатгалд хамрагдалтын тооноос харж болно.

Харин Архангай, Говь-Алтай, Дорнод, Дорноговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Хөвсгөл, Хэнтий аймаг дахь салбарууд сургалт, сурталчилгааны чиглэлээр хангалтгүй ажилласан нь даатгалд хамрагдалт хангалттай биш байгаагаар нотлогдож байна. Шалгалтын явцад Баян-Өлгий, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Хэнтий, Төв, Увс болон нийслэл нийт 1658 иргэнд хуулийн 28.1.1 дэх заалтын дагуу 318.3 сая төгрөгийн хариуцлага тооцжээ. Энэ нь өнгөрсөн оны торгуулийн орлогын дүнгээс 1.7 дахин өссөн үзүүлэлт бөгөөд торгуулийн 94.5 хувь нь Улаанбаатар хотын жолооч нарт ногдуулсан торгууль эзэлж байна.

Дээрх хамтын ажиллагааны хүрээнд Булган аймаг дахь салбараас “Ургац даатгал”, Орхон аймаг дахь салбараас “Мотоцикл” арга хэмжээ, Төв аймаг дахь салбараас “Даатгал 1”, “Даатгал 2”, “Журам 1” болон “Журам 2” зэрэг сэдвээр санаачлан хамтарсан шалгалт явуулжээ.

Тухайлбал, Нийслэл дэх салбар нь ЦЕГ-тай байгуулсан хамтран ажиллах тухай гэрээ болон нийслэлийн тээврийн газартай хамтран батлуулсан удирдамжийн дагуу шалгалт явуулсан. Шалгалтаар 16675 тээврийн хэрэгсэл хамрагдаж 3796 зөрчил илрүүлсэн байна. Хуулийн 28.1.1 заалтын дагуу 1452 иргэнд хариуцлага хүлээлгэжээ. Хуулийн хэрэгжилтийг шалгах хамтарсан шалгалтыг Дорнод, Өвөрхангай, Увс болон Сүхбаатар аймгууд хангалтгүй явуулж, ямар үр дүн гаргасан нь тодорхой бус байна.

АЖДХ, ЦЕГ-тай байгуулсан хамтран ажиллах тухай санамж бичгийн хүрээнд хамтарсан хяналт шалгалтыг нийслэл, орон нутагт тасралтгүй явуулсны үр дүнд хуулийн 28.1.1-д заасны дагуу 1657 иргэнд 318.1 сая төгрөгийн торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. Тухайлбал, нийслэл Улаанбаатар хотод 1577 иргэнийг 302.7 сая төгрөгөөр, Баян-Өлгий аймагт 2 иргэнийг 384.0 мянган төгрөгөөр, Өвөрхангай аймагт 8 иргэнийг 1.5 сая төгрөгөөр, Хөвсгөл аймагт 11 иргэнийг 2.1 сая төгрөгөөр, Говьсүмбэр, Дорноговь аймагт 3 иргэнийг 576.0 мянган төгрөгөөр, Өмнөговь аймагт 10 иргэнийг 1.9 сая төгрөгөөр, Хэнтий аймагт 7 иргэнийг 1.7 сая төгрөгөөр, Төв аймагт 5 иргэнийг 960.0 мянган төгрөгөөр болон Баянхонгор аймагт 6 иргэнийг 1.1 сая төгрөгөөр торгууль оногдуулж хариуцлага тооцжээ. Нийслэл Улаанбаатар нийт торгуулийн 95.1 хувийг эзэлж байна.

Хуулийн 22.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд дээрх торгуулийн орлогын 50 хувийг жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх талаар орон нутаг дахь салбараар дамжуулан санхүү төрийн сангийн хэлтэст удаа дараа шаардаж ажилласан бөгөөд Баян-Өлгий аймаг 192.0 мянган төгрөг, Говьсүмбэр аймаг 672.0 мянган төгрөг, Хөвсгөл аймаг 1.056 сая төгрөг, Хэнтий аймаг 672.0 мянган төгрөгийн торгуулийн орлогыг анх удаа төвлөрүүлсэн бөгөөд бусад аймгууд орон нутгийн төсөвт тодорхой нэрээр тусгагдаагүй учраас шилжүүлэлт хийх боломжгүй гэсэн тайлбар гаргажээ.

Даатгалын санг бүрдүүлэхэд тус Холбооны орон нутаг дахь бүх салбарууд хангалттай ажилласан гэж дүгнэж байна. Ялангуяа Булган болон Ховд айман дахь салбарууд даатгалын санг

бүрдүүлэх чиглэлээр засаг даргын захирамж, хамтран ажиллах санамж бичиг боловсруулан батлуулж ажилсан нь сайшаалтай байна.

Тус Холбооны орон нутаг дахь салбарын нэгэн чухал үүрэг бол даатгалын тохиолдлын газар дээрх үзлэг явуулж баримтжуулан даатгалын тохиолдлын улмаас хохирогчид нөхөн төлбөр олгох боломжийг даатгагч, даатгалын сан, даатгуулагч, хохирогчид бүрдүүлэн өгч ажиллах явдал юм. Баян-Өлгий аймагт-1, Дархан-Уул аймагт-1, Сэлэнгэ аймагт-1 болон нийслэл Улаанбаатар хотод 16 даатгалын сангийн дуудлагыг тус тус хүлээн авсан бөгөөд бусад аймагт дуудлага байхгүй байна. Даатгалын сангийн дуудлага байхгүй, цөөн байгаа шалтгааныг орон нутгийн замын цагдаагийн тасагтай хамтран ажиллах, даатгалын сангийн ач холбогдлыг иргэн бүрт хүргэх сурталчилгаа сайн хийгдэж хамралт сайн байгаатай холбож үзэж болох боловч бид анхаарах ёстой.

Даатгалын сан нь Хэнтий, Төв, Говь-Алтай, Сэлэнгэ, Дархан-Уул болон Ховд аймаг дахь салбараас ирүүлсэн нөхөн төлбөр олгох материалын бүрдлийг хянаж даатгалын тохиолдлын 7 хохирогчид 13.7 сая төгрөгийн нөхөн төлбөр олгов.

Холбоо нь орон нутагт “Ард даатгал” ХХК, “Соёмбо даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “МИГ даатгал” ХХК, “Мөнх даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Гэр даатгал” ХХК болон “Соёмбо даатгал” ХХК-тай даатгалын тохиолдлын дуудлагыг хүлээн авч үйлчилгээ үзүүлэх тухай гэрээг байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2014 онд нийт 489 даатгалын тохиолдлын дуудлаганд явж материалыг зохих журмын дагуу бүрдүүлэн үйлчилгээ үзүүлсэн байна.

Холбооны хяналт, бүртгэлийн дотоод програмд “Дуудлагын бүртгэл” гэсэн бүртгэлийн програмыг шинээр боловсруулан мөрдүүллээ. Энэ програмыг ашигласнаар орон нутаг дахь салбаруудын дуудлагын утсанд ирж буй дуудлагын бүртгэлийг тухай бүр хянаж, хяналт тавих боломжтой болсон. Бүртгэлийг Даатгалын байгууллагын тухай мэдээлэл лавлалагаа, жолоочийн хариуцлагын даатгал, жолоочийн хариуцлагын даатгалын тохиолдол, Мэдээллийн сангийн лавлагаа, Торгуулийн тухай лавлагаа, тээврийн хэрэгслийн даатгалын тохиолдол, утасны лавлагаа болон бусад гэсэн 10 төрлөөр мэдээлэл авч байгаа. Өнгөрсөн онд салбаруудын утсанд нийт 3757 дуудлага ирснээс даатгалын тохиолдлын дуудлага 828, мэдээллийн сангийн лавлагаа 302, бусад лавлагаа 2627 бүртгэлээ.

Цаашид орон нутаг дахь салбарын үйл ажиллагааг улам идэвхжүүлж, хамтран ажиллах холбогдох байгууллагуудтай хүчээ нэгтгэн ажилдаг байхаар шаардлага тавих болно. Салбарын боловсон хүчнийг чадавхижуулахад илүү анхаарал тавигдана.

2.2 ХОЛБООНЫ ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН НЭГ НЬ ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВЧ ГАЗАР ДЭЭРХ ҮЗЛЭГ ХИЙХ, ХОХИРОГЧИД ОЛГОХ НӨХӨН ТӨЛБӨРИЙГ ШУУРХАЙ ҮНЭН ЗӨВ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГТЭЙ ШУУРХАЙ АЛБАНЫ ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЯВДАЛ ЮМ.

Холбооны дүрмийн 2.6 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 395 дугаар тогтоол, Холбооны удирдах зөвлөлийн хурлын 2013 оны Салбар байгуулахыг зөвшөөрөх тухай тогтоолын дагуу Холбооны чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий салбарыг 20 аймагт байгуулсан. Холбооны салбарууд нь даатгагч, даатгуулагч, хохирогч, иргэнээс 24 цагийн турш даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авч, даатгалын тохиолдлын газар дээрх үзлэг хийж даатгалын тохиолдлын бичиг баримтыг шуурхай бүрдүүлж, нөхөн төлбөрийг үнэн зөв тодорхойлох чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаа.

Мөн Удирдах зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хурлаас зам тээврийн ослын улмаас учирсан хохирлыг төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалах зорилгоор хөдөө орон нутагт зарим даатгалын компаниудын шуурхай албаны үүргийг Холбооны салбараар гүйцэтгүүлэх шийдвэр гарсан бөгөөд уг шийдвэрийн дагуу Соёмбо даатгал, Бодь даатгал, Ард даатгал, Гэр даатгал, Миг даатгал, Мөнх даатгал, Монре даатгал, Номин даатгал, Практикал даатгал, Мандал женерал даатгал зэрэг 10 даатгалын компанитай хамтран ажиллах гэрээ байгуулсны дагуу дээр дурьдсан даатгагч нарт даатгуулсан даатгуулагчийн гаргасан даатгалын тохиолдлын дуудлагыг хүлээн авч, газар дээрх үзлэг хийж холбогдох бичиг баримтыг даатгагчид хүлээлгэн өгч байна.

Холбоо нь мэдээллийн нэгдсэн санг бий болгох зорилгоор ERP буюу Дуудлагын бүртгэлийн програмыг 2014 оны 03 дугаар сард ашиглалтанд оруулсан бөгөөд уг програмд даатгалын сангийн шуурхай албаны бүх дуудлага бүртгэгддэг. Даатгалын тухай хуулийн 12¹.3.2 дах хэсэгт заасан чиг үүргийнхээ дагуу 2014 оны 03 дугаар сараас хойш дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

Хүснэгт №13

д/д	Орон нутгийн салбарын нэр	Нийт дуудлага	Шуурхай албаны дуудлага		Даатгалын тохиолдлын газар дээрх үзлэг	
			Даатгалын сангийн дуудлага	Даатгалын компанийн гэрээт дуудлага	Даатгалын сан	Даатгалын компани
1	Архангай	73	-	1	-	1
2	Баянхонгор	125	-	14	-	-
3	Баян-Өлгий	325	1	1	1	-
4	Булган	245	-	25	-	31
5	Говь-Алтай	190	-	3	-	3
6	Дархан-Уул	214	1	21	1	31
7	Дорноговь	147	-	-	-	-
8	Дорнод	2	-	-	-	-
9	Дундговь	-	-	-	-	-
10	Завхан	73	-	16	-	15
11	Орхон	419	-	520	-	283
12	Өвөрхангай	291	-	20	-	20
13	Өмнөговь	225	-	82	-	82
14	Сүхбаатар	249	-	2	-	-
15	Сэлэнгэ	366	1	14	1	4
16	Төв	200	-	22	-	-
17	Увс	103	-	9	-	8
18	Улаанбаатар	624	16	-	16	-
19	Ховд	130	-	43	-	-
20	Хөвсгөл	142	-	35	-	11
21	Хэнтий	139	-	-	-	-
Нийт дүн		4282	19	828	19	489

Хүснэгт №14. Шуурхай албаны гэрээт дуудлагын дэлгэрэнгүй

д/д	Аймаг нийслэл	Ард	Бодь	Гэр	Миг	Монх	Моңре	Номин	Соёмбо	Практикал	**хаан	**мандал	**монгол	**тэнгэр	Тоо
1	Архангай	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1
2	Булган	2	2	2	12	-	-	3	-	6	-	-	-	4	31
3	Говь-Алтай	-	-	-	-	-	-	-	1	1	-	-	1	-	3
4	Дархан-Уул	2	-	1	-	2	9	-	1	14	-	2	-	-	31
5	Завхан	-	1	-	9	-	-	3	-	-	-	-	1	1	15
6	Өвөрхангай	3	3	-	1	-	-	7	-	4	2	-	-	-	20
7	Өмнөговь	12	11	-	6	-	4	12	6	13	3	1	2	12	82
8	Орхон	104	25	4	-	1	27	57	-	58	-	2	-	5	283
9	Увс	1	-	-	-	-	-	-	2	4	-	-	-	1	8
10	Сэлэнгэ	-	-	-	-	1	-	1	-	-	2	-	-	-	4
11	Хөвсгөл	1	2	-	3	-	-	-	1	4	-	-	-	-	11
Дүн		126	44	7	31	4	40	89	11	104	7	5	4	23	489

Аймаг нийслэлийн салбарын шуурхай алба нь Жолоочийн даатгалын тухай хуулийн “Жолоочийн даатгалд даатгуулаагүй жолооч замын хөдөлгөөнд оролцохгүй байх” гэсэн зарчмын хэрэгжилтийг хангахын тулд Мэргэжлийн хяналтын газрын Автотээврийн хяналтын улсын байцаагч, Татварын хэлтсийн татварын улсын байцаагч, Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тасагтай хамтарсан шалгалтыг зохион байгуулж ажиллаа.

Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих чиглэлээр АЖДХ нь Цагдаагийн ерөнхий газартай хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулсан. Энэ хамтын ажиллагааны хүрээнд аймаг, нийслэл дэх салбараас тухай орон нутгийн Цагдаагийн газрын Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хэлтэстэй хамтарсан шалгалтыг сар бүр тогмол явуулж ажиллалаа. Тайлант хугацаанд нийт 64360 тээврийн хэрэгслийг шалгаж, даатгалгүй болон даатгалын гэрээний хугацаа дууссан 12191 зөрчил илрүүлэн албан журмын даатгалд хамруулан ажиллажээ. Хүснэгт №15-аас харж болно.

Хүснэгт №15. Хяналт, шалгалтын дэлгэрэнгүй мэдээ

д/д	Салбарын нэр	Шалгалтанд хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо	Илэрсэн зөрчлийн тоо
1	Архангай	449	98
2	Баян-Өлгий	2122	86
3	Баянхонгор	2610	537
4	Булган	1645	416
5	Говь-Алтай	1698	53
6	Дархан-Уул	1370	138
7	Дундговь	925	46
8	Дорноговь	473	0
9	Дорнод	395	69
10	Завхан	791	141
11	Өвөрхангай	1223	195
12	Өмнөговь	588	91
13	Орхон	679	92
14	Төв	3184	54
15	Увс	2085	144
16	Сүхбаатар	18532	5120
17	Сэлэнгэ	597	33
18	Хөвсгөл	966	228
19	Хэнтий	4728	263
20	Ховд	3098	502
21	Нийслэл	16675	3796
Нийт		64360	12191

2.3 ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ ҮНЭН ЗӨВ БҮРДҮҮЛЭХ ЯВДАЛ ЮУ ЮУНААС ЧУХАЛ БАЙХ БОЛНО.

2014 он мэдээллийн сангийн хувьд томоохон дэвшил өөрчлөлт гаргах жил байлаа. Даатгалын компани бүр өөрийн програмаар даатгалын гэрээ, нөхөн төлбөрийн мэдээллийг нэгтгэж Албан журмын даатгагчдын холбооны АМИС програмтай холбох замаар мэдээлэл цуглуулах ажил эхний хагас дуустал явагдлаа. Энэ арга зам төдийлөн дэвшил авч ирээгүй төдийгүй гэрээний мэдээлэл нэгтгэхэд хугацаа алдах үнэн зөв чанартай мэдээлэл төвлөрүүлж чадахгүй болохыг тодорхой харууллаа. Албан журмын даатгагчдын холбоо 2012 онд АМИС програмыг боловсруулахад тендер зарлаж 51,0 сая төгрөгийн зардал гаргасан ч ажлын өгөөж хангалтгүй хэвээр байв.

2014 оны эхний хагас жилд мэдээллийн сангийн захирал, бүртгэл мэдээлэл цуглуулах, лавлагаа олгох хоёр, даатгалын компаниудын мэдээлэл нийлүүлэх ажилд хяналт тавих үүрэгтэй нэг нийт 4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байсан ч мэдээллийн санг удирдлагаар хангах болон АМИС системийн тусламжтайгаар мэдээлэл цуглуулахад мэргэжлийн боловсон хүчин үнэхээр дутагдаж байв.

АМИС системийн хүндрэл, зохион байгуулалтын алдааг засаж жолоочийн даатгалын холбогдох мэдээллийг цуглуулах, цаашид цуглуулсан мэдээлэл нь даатгалын зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж

чадахуйц байхаар бололцоог бүрдүүлсэн даатгалын нэгдсэн системийг бий болгох шаардлага тулгарсан нь тодорхой болсон учир шинээр МИИС системийг боловсруулах зорилт бидний өмнө тулгарсан юм. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд мэдээллийн санд мэргэжлийн туршлагатай боловсон хүчнээр хангах, бэлтгэх зорилт тавьж ажилласнаар тодорхой ахиц бий болгож чадсан. Солонгос улсаас 6 сараар зөвлөх авч ажиллуулсан. Энэ бүхний үр дүнд одоогийн МИИС системийн бүтцийг боловсруулж програм боловсруулах ажлыг өөрсдийн хүчээр хийж байна.

МИИС системийг боловсруулах, бэлэн болгосон програмыг тестлэх турших ажлыг зэрэг явуулсан бөгөөд хэрэгжүүлэхдээ даатгалын компани, даатгалын зуучлагч компаниудаас холбогдох мэргэжлийн хүмүүсийг ажлын хэсэгт оруулж системийн үндсэн зарчим, хэрэгжүүлэх аргаа тогтоож системийг тестлэх ажилд тэднийг оролцуулж байв. Системийн бүтэц, загвар гаргахдаа Солонгос улсын мэргэжилтэн нартай хамтран ажиллаж сайн туршлага, шинэ санааг тусгаж ажиллалаа.

Системийг хэрэгжүүлэх бэлтгэл болгож аймаг орон нутаг дахь даатгалын байгууллагын салбар нэгжүүдийн сүлжээний нөхцөл чадамжид дэлгэрэнгүй судалгаа хийж шаардлага хангахгүй байгаа компанид анхааруулга өгч ажилласан нь зохих үр дүнгээ өгсөн юм. МИИС системийн гэрээ байгуулах, лавлагаа олгох, даатгалын хураамж тооцооллын дэд системийг 7 дугаар сарын 1-ээс ашиглаж эхэлсэн ба нөхөн төлбөрийн дэд систем, даатгалын зууч, АЖДХ-ны ашиглах статистик судалгаа, шинжилгээ тайлангийн дэд системүүдийг 7 дугаар сарын 16-аас эхлэн нэвтрүүлж ашиглалтанд оруулсан. Үндсэн үйл ажиллагааны системийг 8 дугаар сарын 1-ээс ажиллуулж эхэлсэн.

МИИС Системийн талаар даатгалын компаний захирал, Санхүүгийн зохицуулах хорооны нийт удирдлагуудад 5 дугаар сарын 22-нд танилцуулж саналыг нь сонссон. Төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох ажлыг дата төвтэй хамтран гэрээ байгуулж хэрэгжүүлж бэлэн болсон ба “Smartcar.mn” сайт, замын цагдаагийн “Police reader” төхөөрөмжид даатгалын мэдээллийг шалгах боломжтой болж 5 дугаар сарын 28-аас туршилтын журмаар ашиглаж одоо хэвийн ажиллаж байна.

Даатгалын компани, Даатгалын зуучлагч нартай хамтран ажиллаж програмын техникийн шийдэл гаргаж Төрийн банктэй сүлжээний холболттой болсон.

Системийг хэрэгжүүлэхэд шаардагдах мобайл даатгал, гадаад холболт, хохирол үнэлгээ, нөхөн төлбөр статистик тайлангын систем зэрэг дэд системүүдийг холбогдох компанитай гэрээ байгуулж хамтран ажилласаны үр дүнд үйл ажиллагаандаа нэвтрүүлээ.

Гар утасны мессеж үйлчилгээг ашиглаж даатгалын гэрээ хийх системийг Миг даатгал компаний захиалгаар боловсруулсаныг нэмэлт боловсруулалт хөгжүүлэлт хийж Албан журмын даатгагчдын холбооны шинэ системтэй холбож нийт даатгалын компани түүний салбаруудад ашиглахад бэлэн болгосон ба туршилт тестийг хийж гүйцэтгэсэн. Мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан АМИС системийн мэдээллийг МИИС-т хөрвүүлэх, шинэ системд шилжих төлөвлөгөө гаргаж, 5 дугаар сарын 26, 28-нд Хаан банк, Хас банк, Төрийн банк, Хүннү сиед, Ачит ундарга, Сүрэг хараацай, Капитал банк, Си эн эн икс, Лоялти солюшин, Эй Эс Ай Би, Гэрэлт буян ундрах зэрэг 12 зуучын компани, 5 дугаар сарын 27,29-нд Миг, Ард, Тэнгэр, УБ хотын даатгал, Мөнх, Монре, Практикал, Гэр, Монгол, Соёмбо, Мандал даатгалын компаниудын ажилтнуудад сургалт хийлээ. Мөн тус сургалтаар даатгалын компаниудаас шинэ системд тусгах хэд хэдэн санал гарч түүнийг нь хүлээн авч шинэ системд тусгав. Холбооноос зохион байгуулсан сургалтанд Бодь даатгал компани оролцоогүй бөгөөд өөрийн байран дээрээ сургалт авах хүсэлт гаргасан учир 6 дугаар сарын 5-нд 14 ажилтанд дахин сургалт зохион байгуулсан болно. Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн технологийн хэлтсийн зөвлөмжийн дагуу мэдээллийн сангийн сүлжээний бүтэц хамгаалалтыг шинэ системд нийцүүлэн сайжруулах хяналт тавих боломж бий болгов. Гэхдээ цаашид хийх ажил их байна. Санхүүжилт шаардлагатай байна.

Шинэ систем нэвтрүүлэх төлөвлөгөөний хүрээнд вебээр дамжуулан гараар лавлагаа авах

АМИС системийг 7 дугаар сарын 1-ээс үйлчилгээг нь зогсоож мэдээллийн нэгдсэн шинэ системд бүрэн шилжиж ажиллах шаардлага тавьж холбогдох арга хэмжээнүүдийг тухай бүр авч ажиллалаа.

МИИС систем нь 14 дэд системийг багтаасан бөгөөд удирдлага арга зүй зохион байгуулалтын талаас нь гүйцэтгэх захирал, мэдээллийн сангийн захирал нарын хамтран ажилласан ажлын томоохон үр дүн гэдгийг зориуд тэмдэглэж байна.

Мэдээллийн сангийн сервер сүлжээний үйл ажиллагаанд мониторинги хяналт тавих хяналтын дэлгэцүүдийг байршуулж холбогдох тохиргоо хийж программыг ажилд оруулав. Мэдээллийн санд шинээр ажилд авсан ажилтан нарт холбогдох анхан болон шаардагдах мэдлэг сургалтуудыг тухай бүр хийж байна.

Мэдээллийн сангийн МИИС системийн нөөц хуулбар санг үндэсний дата төв дэх серверт байршуулав. Даатгалын гэрээ хийгдэх, нөхөн төлбөр бүртгэгдэх бүрд нөөц санд орж байхаар зохион байгуулсан болно. МИИС системийн хэвийн найдвартай ажиллагааг хангахаар өгөгдөлийн санд тохируулга зүгшрүүлэлт хийж системийн хурдыг 10 дахин нэмэгдүүлэв.

Даатгалын компани, зуучлагч нар байгуулсан гэрээний мэдээлэл болон тухайн гэрээний нэмэлт мэдээллийг тухай бүр авч ашиглах боломжийг олгох програмыг нэмэлтээр боловсруулав.

МИИС системд бүртгэгдэж байгаа даатгалын гэрээний мэдээллийг тухай бүр smartcar.mn, Police Reader төхөөрөмжүүдээр ашиглагдах боломжтой болгож өөрчлөлт хийв. Зам тээврийн яаманд тухай бүр даатгалын гэрээний мэдээллийг илгээх, тээврийн хэрэгслийн мэдээллийг онлайнаар татаж МИИС системд ашиглах холболтыг хийж гүйцэтгэсэн болно.

Хохирол үнэлгээний програмыг МИИС системтэй холбох талаар техникийн шийдэл гаргаж хамтран хэрэгжүүллээ. МИИС системийг ашиглах гарын авлага бэлэн болгов. Холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулж танилцуулга, хэрэгцээ шаардлага, хэрхэн ажиллах сургалт зохион байгуулсаар байна.

Даатгалын хугацаа нь дуусаж байгаа тээврийн хэрэгслийн мэдээллийг боловсруулж гар утасны дугаараар нь цацах мэдээллийг бэлтгэж нэг сар туршиж үр дүнг гаргав. Жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд нэгтгэгдсэн даатгалын гэрээний мэдээллийг 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулбал:

д/д	Нэрс	Хувь хүн		Хуулийн этгээд		Мэргэшсэн, С, D		Дамжин өнгөрөх		Нийт гэрээний тоо	Нийт хураамжийн дүн
		Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамж дүн		
1	Соёмбо даатгал	18.958	593,650.385	5193	386,883.704	935	30,726.548	-	-	25.086	1,011,260.637
2	Миг даатгал	62.173	1,821,751.351	16.567	977,370.151	1,768	57,971.347	-	-	80.508	2,857,092.849
3	Мөнх даатгал	181	6,697.128	912	77,921.547	417	13,787.400	-	-	1510	98,406.075
4	Монгол даатгал	69.509	2,301,794.588	15.699	1,179,180.631	3,037	100,387.069	432	34,078.609	88.677	3,615,440.897
5	Практикал даатгал	29.419	917,128.807	6215	412,999.984	667	22,674.465	-	-	36.301	1,352,803.256
6	Гэр даатгал	352	11,977.490	267	19,113.267	5	151.800	-	-	624	31,242.557
7	Улаанбаатар хотын даатгал	98	3,437.116	114	10,350.630	90	3,348.180	-	-	302	17,135.926
8	Номин даатгал	32.056	1,053,678.586	7142	454,389.021	860	28,911.727	-	-	40.058	1,536,979.334
9	Тэнгэр даатгал	25.500	813,421.724	7976	584,312.597	445	14,543.229	-	-	33.921	1,412,277.550
10	Бодь даатгал	75.456	2,437,294.459	12.361	795,059.343	777	24,852.051	-	-	88.594	3,257,205.853
11	Ган зам даатгал	523	17,341.711	250	14,299.424	67	2,008.050	-	-	840	33,649.185
12	Монре даатгал	23.291	758,251.257	7259	421,623.227	278	9,199.575	-	-	30.828	1,189,074.059
13	Ард даатгал	37.147	1,188,234.895	8459	606,373.331	2,464	87,381.447	-	-	48.070	1,881,989.673
14	Моннис даатгал	29	1,141.965	245	26,491.801	199	6,182.055	-	-	473	33,815.821
15	Мандал даатгал	8650	307,425.948	4031	276,266.186	421	13,787.812	-	-	13.102	597,479.946
16	Хаан даатгал	9003	284,459.493	1559	121,750.382	400	13,032.103	-	-	10.962	419,241.978
Нийт дүн		392.345	12,517,686.903	94.249	6,364,385.226	12.830	428,944.858	432	34,078.609	499.856	19,345,095.596

Даатгагч зуучлагч нар эдгээр гэрээг хийхийн тулд АЖДХ-ны мэдээллийн нэгдсэн санг ашиглаж байгаа төдийгүй гэрээний 2-3 үзүүлэлтээс бусдыг бэлэн програм ашиглаад онлайнаар хийх боломжийг бүрдүүлж өгсөн байгаа.

Төрийн банк, Хаан банктай хамтран ажиллах гэрээ байгуулж МИИС системийг энэ 2 банкны системтэй холбож чадсан нь сум, суурийн газарт жолоочийн даатгалын гэрээг онлайнаар хийх боломжийг бий болголоо. АЖДХ, даатгагч нараас 2014 онд хийсэн олон ажлын үр дүнд жолоочийн даатгалд хамрагдалт 35.9 хувиар, хураамжийн орлогын хэмжээ 27.6 хувиар тус тус өссөн байна.

Холбооны гишүүн даатгалын компани жолоочийн даатгалын үйл ажиллагааг хөнгөвчлөх, даатгуулагчид үзүүлэх үйлчилгээг хурдан шуурхай, боловсронгуй болгох зорилгоор Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн лавлагааг цахим хэлбэрээр 2013 оноос эхэлж олгосон. 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Холбооны гишүүн даатгалын компани болон даатгалын зуучлагч компаниудад даатгуулагч болон тээврийн хэрэгслийн талаар 1,456.289 удаа лавлагаа олгож даатгагч, зуучлагч нарт үйлчилсэн байна.

Хүснэгт №17. Жолоочийн даатгалын гэрээ хийхэд лавлагаа авсан мэдээ

д/д	Даатгалын компани	Лавлагааны төрөл			Нийт дүн
		Веб	Сервис	МИИС	
1	Мөнх даатгал	141	972	153	1.266
2	Номин даатгал	284	55.682	34.191	90.157
3	Миг даатгал	141	97.974	79.028	177.143
4	Соёмбо даатгал	2.260	17.913	14.922	35.095
5	Ард даатгал	44	53.685	51.548	105.277
6	Монгол даатгал	9.872	103.068	87.786	200.726
7	Моннис даатгал	7	981	389	1.377
8	Тэнгэр даатгал	0	54.539	39.320	93.859
9	Бодь даатгал	2.898	231.108	99.555	333.561
10	Монре даатгал	1.533	32.684	46.860	81.077
11	Улаанбаатар хотын даатгал	2	364	650	1.016
12	Практикал даатгал	35	83.307	14.387	97.729
13	Гэр даатгал	689	1.476	941	3.106
14	Мандал даатгал	1.906	18.214	25.308	45.428
15	Ган зам даатгал	50	1.037	1.247	2.334
16	Хаан даатгал	949	20.849	7.656	29.454
17	Гэрэлт буян ундрах	4.302	-	-	4.302
18	Эрсдлийн шийдэл	17.134	117.235	-	134.369
19	Төрийн банк	4	17.525	-	17.529
20	АЖДХ	1.484	-	-	1.484
Нийт		43.735	908.613	503.941	1,456.289

Хүснэгт №18. 2014 оны жолоочийн даатгалын гэрээний хураамжийн орлого, олгосон нөхөн төлбөрийн хэмжээг компани тус бүрээр харьцуулсан дүн

д/д	Нэрс	Нийт хураамжийн дүн	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Хувь
1	Соёмбо даатгал	1,011,260.637	454,831.586	45.0%
2	Миг даатгал	2,857,092.849	1,479,747.748	51.8%
3	Мөнх даатгал	98,406.075	41,265.931	41.9%
4	Монгол даатгал	3,615,440.897	2,175,488.786	60.2%
5	Практикал даатгал	1,352,803.256	1,067,958.499	78.9%
6	Гэр даатгал	31,242.557	37,903.077	121.3%
7	Улаанбаатар хотын даатгал	17,135.926	2,289.000	13.4%
8	Номин даатгал	1,536,979.334	1,112,817.813	72.4%
9	Тэнгэр даатгал	1,412,277.550	690,585.385	48.9%
10	Бодь даатгал	3,257,205.853	1,946,929.069	59.8%
11	Ган зам даатгал	33,649.185	26,578.450	79.0%
12	Монре даатгал	1,189,074.059	627,090.136	52.7%
13	Ард даатгал	1,881,989.673	1,144,688.051	60.8%
14	Моннис даатгал	33,815.821	1,567.600	4.6%
15	Мандал даатгал	597,479.946	371,711.487	62.2%
16	Хаан даатгал	419,241.978	104,243.724	24.9%
Нийт дүн		19,345,095.596	11,285,696.342	58.3%

Жолоочийн даатгалын үйл ажиллагааг даатгалын зөвшөөрөлтэй 16 компани хэрэгжүүлж даатгалын хураамжийн орлогоос хохирогчид олгосон нөхөн төлбөрийн зардал гол байр эзэлж байна. Хүснэгт №18

2014 оны даатгалын хураамжийн нийт орлогод олгосон нөхөн төлбөрийн нийт зардал 58.3 хувийг эзэлж байна. Энэ хувь өнгөрсөн онд 54 хувь байсан болно. Нөхөн төлбөрийн зардал 60 хувиас давсан даатгалын компаниудад Санхүүгийн зохицуулах хороо зохих шалгалт хийж дүгнэлт гаргавал зохино.

Хүснэгт: Жолоочийн даатгалын гэрээ, нөхөн төлбөрийн дүн /газар нутгийн байршлаар/

д/д	Нэрс	Даатгалын гэрээний тоо	Хураамжийн дүн	Даатгалын тохиолдлын тоо	Нөхөн төлбөрийн дүн	Хувь
1	Архангай	7598	231,908.672	51	28,811.428	12.43
2	Баян-Өлгий	7529	222,746.196	70	31,330.523	14.06
3	Баянхонгор	8442	236,924.936	19	11,595.865	4.89
4	Булган	6083	177,516.670	44	43,199.222	24.38

5	Говь-Алтай	6911	211,124.106	35	23,829.215	11.29
6	Говьсүмбэр	2270	81,729.458	38	26,341.418	33.25
7	Дархан-Уул	11.636	415,131.354	327	165,582.731	39.91
8	Дорноговь	9090	316,517.956	103	79,960.935	25.28
9	Дорнод	7213	211,283.702	56	34,068.747	16.12
10	Дундговь	6237	171,288.127	40	27,542.020	16.13
11	Завхан	5882	182,749.256	34	24,680.771	13.51
12	Орхон	14.705	516,895.469	439	215,254.191	41.71
13	Сэлэнгэ	11.957	382,728.646	157	138,482.041	36.23
14	Сүхбаатар	6907	208,123.345	23	11,985.215	5.76
15	Төв	10.981	337,845.602	128	188,691.285	55.87
16	Увс	7320	209,820.531	47	21,636.700	10.31
17	Улаанбаатар	319.875	13,597,897.121	21,140	10,132,470.857	74.26
18	Ховд	6130	183,396.032	39	21,565.234	11.76
19	Хэнтий	8613	264,031.404	61	50,821.347	19.26
20	Хөвсгөл	12.478	376,903.795	83	40,648.364	10.78
21	Өвөрхангай	10.740	306,389.156	55	35,975.524	12.0
22	Өмнөговь	10.827	468,065.453	100	81,717.769	17.46
Нийт		499.424	19,311,016.987	23.089	11,436,191.402	59.11

Жолоочийн даатгалд хамрагдалт:

2014 онд техникийн хяналтын үзлэг, оношилгоонд хамрагдсан, татвар төлсөн болон улсад бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн тоотой харьцуулахад жолоочийн даатгалд хамрагдалт дараах байдалтай байна. Хүснэгт №19

Хүснэгт №19. Техникийн хэрэгслийн хамрагдалт

/2014.12.31-ний байдлаар/

д/д	Аймаг, нийслэл	Монгол улсад бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн тоо	Техникийн үзлэгт орсон нийт тээврийн хэрэгслийн тоо	АТӨЯХАТ төлсөн тээврийн хэрэгслийн тоо	Жолоочийн даатгалын гэрээний тоо
1	Архангай	9180	8359	8451	7533
2	Баянхонгор	15.978	9937	6785	8138
3	Баян-Өлгий	14.102	8686	5883	7451
4	Булган	10.908	8242	6441	5885
5	Говь-Алтай	8394	7162	5246	6178
6	Говьсүмбэр	2592	3202	1576	2134
7	Дархан-Уул	17.324	11.350	10.856	11.199
8	Дорноговь	15.843	8117	8972	8291
9	Дорнод	12.831	9429	7227	6874
10	Дундговь	7642	8058	3743	5868
11	Завхан	11.041	8629	5178	5667
12	Орхон	19.824	12.325	12.783	13.201
13	Өвөрхангай	15.600	10.584	7992	10.993

14	Өмнөговь	21.197	23.247	12.300	10.034
15	Сүхбаатар	9688	7504	4981	6528
16	Сэлэнгэ	17.014	13.545	8857	11.296
17	Төв	14.600	10.183	7456	10.633
18	Увс	10.855	8337	4480	7094
19	Ховд	13.066	8264	6531	5822
20	Хөвсгөл	17.958	14.094	9001	11.701
21	Хэнтий	9022	8545	5701	8280
22	Улаанбаатар	426.957	264.392	294.368	298.652
Нийт		701616	477309	441808	487026



Жолоочийн даатгалд хамрагдсан гэрээний тооноос /мэргэшсэн жолоочийн 12830 гэрээний тоог хасч график №3-д тооцсон болно./

Жолоочийн даатгалд хамрагдалтыг харьцуулбал

Үзүүлэлт	2013 он	2014 он
ЗТЯ-ны нийт тээврийн хэрэгслийн бүртгэлтэй харьцуулахад	63.43%	69.4%
АТҮТ-н техникийн үзлэгт орсон нийт тээврийн хэрэгсэлтэй харьцуулахад	100.07%	102.3%

2013 онд техникийн үзлэгт хамрагдсан 413692 тээврийн хэрэгслийн тоог 2014 онд импортоор орж ирсэн шинээр бүртгэгдэж улсын дугаар авсан тээврийн хэрэгслийн тоо 84.0 мянгаар нэмэгдүүлж тооцоход 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар даатгалд хамрагдвал зохих замын хөдөлгөөнд идэвхтэй оролцох тээврийн хэрэгсэл 497.698 байж болох байна. Ер нь замын хөдөлгөөнд идэвхтэй оролцогч тээврийн хэрэгслийн тоотой харьцуулахад жолоочийн даатгалд хамрагдалт 97.85 хувьтай байгаа нь өнгөрсөн оноос 4.9 хувиар өссөн байна.

2.4 Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжүүлэх, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх хөшүүрэг болгож чадлаа.

Албан журмын даатгагчдын холбооноос 2014 онд Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зам тээврийн ослыг бууруулах, даатгад хамрагдалтыг нэмэгдүүлэхтэй холбогдуулж даатгуулагч даатгалын төлөөлөгч, зуучлагч нарыг мэдээллээр хангах тэднийг чадавхижуулахад чиглэгдсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж ажиллалаа. Нийт сурталчилгааны ажилд даатгалын сангаас 73.2 сая төгрөг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс 17.4 сая төгрөг зарцууллаа.

1. Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:

МҮОНРадиоогийн “Гурван эрдэнэ” студитэй хамтран “Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт” болон “Даатгалын хохирлын үнэлгээ болон даатгалын зуучлалын тухай” радио нэвтрүүлгүүдийг 10 цувралаар бэлтгэн иргэд сонсогчдод хүргэсэн. Эдгээр нэвтрүүлгүүдэд СЗХ-ны Даатгалын газрын дарга С.Ганболд, Монголын даатгагчдын холбооны ерөнхийлөгч Ж.Бат-Орших, Даатгалын хохирол үнэлэгчдийн холбооны ерөнхийлөгч Ө.Эрдэнэбаяр, Даатгалын зуучлагчдын холбооны Дэд ерөнхийлөгч Б.Анхбаяр, замын цагдаагийн ерөнхий газар, нийслэлийн замын цагдаагийн газрын холбогдох хүмүүс оролцож санал бодлоо илэрхийлсэн.

Жолоочийн даатгалын тухай хууль, түүний эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилтийг ханган биелүүлэхэд тулгамдаж байгаа асуудлууд, иргэд даатгуулагчдын даатгалын боловсролыг нэмэгдүүлэх зэрэг зорилго чиглэлээр “Eagle” TV-д 4 удаа, “Эх орон” TV-д 2 удаа, МҮОНТВ, Молор, LCN, ЕСО, МонголТВ, MN25, 2-р суваг зэрэг телевизийн нэвтрүүлгүүдэд тус бүр 1 удаа оролцож, ярилцлага, тодруулга өгсөн.

Авторадио 96.3 FM-тэй хамтран ажиллах гэрээний дагуу 7 хоног тутам 20 минутийн хугацаатай “Жолоочийн даатгалын цаг” шууд нэвтрүүлгийг жолооч, даатгуулагчдад хүргэж иргэдийн санал бодлыг сонсч, зохих хариулт шууд өгч байна.

Жолоочийн даатгалын тухай хууль түүний хэрэгжилтийн явцад хууль хэрэгжүүлэгч байгууллагуудад тулгамдаж буй асуудлуудыг хамтран шийдвэрлэх арга замыг тодорхой болгох зорилгоор Нийслэлийн алслагдсан дүүргүүдийн ЗЦГ-ын байцаагч, хэрэг бүртгэгч нарын дунд болон Нийслэлийн ЗЦГ-ын удирдлагуудад сургалт, ярилцлага зохион байгуулав.

Нийслэлийн Багануур дүүрэгт зохион байгуулагдсан “Жолоочийн даатгал-таны төлөө” өдөрлөгт оролцогчдод Албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагаа болон Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар сургалт явуулсан.

Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, Албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагаа, бичил даатгалын эрх зүйн орчин зэрэг асуудлаар материал бэлтгэж “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Үндэсний шуудан” сонингуудад нийтлүүлсэн болно.

“Green link” ХХК-тай хамтран даатгуулагчдад жолоочийн даатгалын талаарх цогц ойлголт

өгөх, тэдэнд даатгалын үйлчилгээг ойртуулах, жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний хугацаагаа шалгах, тээврийн хэрэгсэлтэй холбогдох мэдээллийг иргэн хүн өөрийн гар утсаар дамжуулан авч болдог болгох зорилгоор смарт утасны “Автодорцов-Жолоочийн ухаалаг туслах” аппликейшнийг хэрэгжүүлээд байна. Андроид болон IOS системтэй ухаалаг гар утсанд зориулсан “Joloochiin daat-gal” /автодорцов/ аппликейшнаар дамжуулан жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний агуулга, хугацааг шалгах, төлөх хураамжийн хэмжээг тооцоолох баримжаа авах, замын ачаалал, авто засварын газар, шатахуун түгээх газар зэрэг жолооч нарт хэрэгтэй бүх мэдээллийг нэгтгэн хүргэхийг зорилоо. Мөн даатгуулагч таны жолоочийн даатгалын гэрээний мэдээлэл тухай бүр Мэдээллийн нэгдсэн санд орсон байх нь юу юунаас чухал гэдгийг анхаарч, түүнд өөрөө хяналт тавих боломжийг олгож байна.

“Жолоочийн даатгалд иргэд өөрсдөө хяналт тавих боломж нээгдлээ” сэдэвт хэвлэлийн бага хурал зохион байгуулж, MNB, UBS, MN25, MNC, Эх орон ТВ, TV1, 2-р суваг, ZaTV, TV5, TV10, C1, Eagle зэрэг 12 телевиз, “Монголын үнэн”, “Монголын мэдээ” сонин, Olloo.mn, Цаг.mn, Ikon.mn сайтууд, Монцамэ агентлаг, Монголын радиогийн “Хурд” агентлаг зэрэг 22 хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, сурвалжлагачид оролцов.

Vip76.mn сайттай хамтран “Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, ач холбогдол, тулгамдсан асуудлууд” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж хууль санаачлагчид, хэрэгжүүлэгчид, эрдэмтэн судлаач, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн санал бодлыг нэгтгэн дүгнэлээ. Уг хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн Ц.Нямдорж, С.Ганбаатар, МУИС-ийн ЭЗС-ийн багш Д.Жавхланцогт, Албан журмын даатгагчдын холбооны Гүйцэтгэх захирал Д.Цэвээнжав, Монголын даатгагчдын холбооны ерөнхийлөгч Ж.Бат-Орших, Даатгалын хохирол үнэлэгчдийн холбооны ерөнхийлөгч Ө.Эрдэнэбаяр, Даатгалын зуучлагчдын холбооны Дэд ерөнхийлөгч Б.Анхбаяр, “Соёмбо даатгал” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Баттулга, “Мандал женерал даатгал” ХХК-ийн иргэд хариуцсан захирал Б.Жавхлан, Албан журмын даатгагчдын холбооны Дархан-Уул аймаг дахь салбарын менежер С.Сугар, жолооч Ж.Наранпүрэв, Ц.Баасанцэрэн нарын зэрэг хүмүүс оролцож Жолоочийн хариуцлагын даатгалын хуулийн хэрэгжилт, ач холбогдол, тулгамдаж буй асуудлаар байр сууриа илэрхийлсэн байна.

Жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдаагүй жолооч замын хөдөлгөөнд оролцохыг хуулиар бүрмөсөн хориглосон учраас хувь хүнийг даатгалын хугацаа дууссан үедээ болзошгүй осол зөрчил гаргаж эдийн засгийн эрсдэлд орохоос сэргийлэхийн тулд жолоочийн даатгалын гэрээний дуусах хугацааг даатгуулагчид сануулах шаардлага гарч байна. Мэдээлэл олон хэрэглэгчид нэгэн зэрэг хүрэх маркетингийн давуу талыг ашиглаж “Тулгат маркетер” ХХК-иар дамжуулан 2014 оны 12 дугаар сарын 10-наас 31-ний хооронд жолоочийн даатгалын гэрээний хугацаа нь дуусах үүрэн телефоны бүх операторын хэрэглэгч 7100 даатгуулагчид гэрээгээ сунгахыг сануулсан SMS хүргэсэн нь эргэх холбоо сайтай даатгуулагчдын талархлыг хүлээсэн үйл ажиллагаа болсон.

2. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

МҮОНРадиогийн “Гурван эрдэнэ” студи, “Авто радио сонин” нэвтрүүлэгтэй хамтран зам, тээврийн ослыг бууруулах түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн агуулга бүхий нийт 10 цуврал нэвтрүүлгийг бэлтгэн иргэд, сонсогчдод хүргэсэн.

ТВ8 телевизийн “Гарц” нэвтрүүлэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу зам, тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Жолоочийн даатгалын хуулийн талаар дэлгэрэнгүй тайлбар сурталчилгаа хийх, хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэх зэрэг агуулга бүхий нэвтрүүлгүүдийг 7 хоног тутам бэлтгэн явуулж байна.

Авторадио 96.3 FM-тэй хамтран ажиллах гэрээний дагуу 7 хоног тутам 20 минутын хугацаатай “Жолоочийн даатгалын цаг” шууд нэвтрүүлгийг жолооч, даатгуулагчдад хүргэж байна.

Жолооч, явган зорчигчдод хандаж “Зам тээврийн ослоос сэргийлье” уриалгыг 9 дүгээр сард гаргасан. Уриалгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, түүний хор хохирлыг ард иргэдэд ойлгуулах зорилгоор УБ хотын ЗЦГ-тай хамтран “Зам, тээврийн ослын улмаас хохирсон иргэдийн дуу хоолойг сонсох өдөр” олон нийтийн цуглаан зохион байгуулсан.

УБ хотын ЗЦГ-тай хамтран “Зам, тээврийн ослын улмаас хохирсон иргэдийн дуу хоолойг сонсох өдөр” арга хэмжээний хүрээнд Холбооны Гүйцэтгэх захирал Д.Цэвээнжав “Eagle” ТВ-ийн “Зочны цаг”, “ЕТҮ”-ийн “Тод зочин”, “MNC”ТВ-ийн “Мэдээ”; МҮОНРадиогийн “Хурд” агентлаг, “Соёмбо” хууль зүйн нэвтрүүлэг, ТВ8, UBS, GoGo.mn, Shuud.mn, News.mn зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, түүний хор уршиг, Жолоочийн даатгалын тухай хуулийн зорилго, ач холбогдол болон хэрхэн хэрэгжиж байгаа талаар мэдээлэл, ярилцлага өгсөн.

АЖДХ-ноос гаргасан “Зам, тээврийн ослоос сэргийлье” уриалгыг олон нийтэд илүү хүртээмжтэй видео хэлбэрээр хүргэх зорилгоор “Монголын шинжлэх ухааны хялбаршуулсан баримтат кино бүтээлчдийн нийгэмлэг”-тэй хамтран “Монгол хүн- Монголын баялаг” 7 ширхэг сэрэмжүүлэгийг орон нутагт хүргээд байна.

3. ДААТГАГЧ, ЗУУЧЛАГЧ НАРЫГ ЧАДАВХИЖУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

Монголын даатгагчдын холбооноос УБ хотод 2 удаа зохион байгуулсан даатгалын төлөөлөгчийн эрх олгох сургалтанд оролцож 225 хүнд “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал” сэдвээр сургалт явуулсан.

“Ард даатгал”ХХК-ийн салбар, нэгжийн ажилтнуудын нэгдсэн сургалтад оролцож “Жолоочийн даатгалын тухай” хуулийн хэрэгжилтийн асуудлаар сургалт явуулсан.

“Бодь даатгал” ХХК-ийн орон нутгийн салбар, нэгжийн менежерүүдийн 2014 оны сургалт семинарт 2 удаа оролцож, салбар, нэгжийн менежер 72 ажилтанд Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт сэдвээр сургалт явуулсан.

НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх” төслийн ажилтнуудад “Жолоочийн даатгалын тухай хуулийн эрх зүйн орчин” сэдвээр сургалт явуулав.

“Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх” төслийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ажилтнуудыг чадавхижуулах сургалт 5 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулагдаж, Албан журмын даатгагчдын холбооны төв, орон нутаг дахь салбарын 55 ажилтан хамрагдлаа. Сургалтын зорилгыг урьдчилан тодорхойлсон бөгөөд энэхүү үйл ажиллагааны хүрээнд бичил даатгал түүний онцлог, ач холбогдол, нийгмийн даатгалын ач холбогдол, эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, даатгалын хохирлын үнэлгээ, даатгалын зуучлал, банкны даатгалын зуучлал болон Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, Албан журмын даатгагчдын холбооны дотоод ажилтай холбоотой илтгэл, танилцуулга хийгдэж, сургалтанд оролцогсод мэргэжлийн хүмүүсээс сонирхсон асуултдаа дэлгэрэнгүй хариулт авч, даатгалын талаарх мэдлэгээ дээшлүүлээ. Сургалтын үеэр “Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх” төслөөс гаргасан “Даатгал бидний амьдрал” цуврал болон “Хүртээмжтэй даатгал-2014” олон улсын форумын тухай үзүүлж танилцуулсан нь танин мэдэхүйн хувьд ач холбогдолтой, иргэд олон нийтийн даатгалын боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулах цаашдын үйл ажиллагаандаа санаа авч хэрэгжүүлэхэд дөхөмтэй, сонирхол татсан арга хэмжээ болсон юм. Энэхүү үйл ажиллагааны талаарх мэдээллийг МҮОНТВ-ийн Мэдээ,Ярилцлагын цаг, Ийгл ТВ-ийн “Зочны цаг”, Эх орон ТВ-ийн Мэдээний цаг зэрэг нэвтрүүлэгт зохиогдож байгаа арга хэмжээний тухай мэдээлэл өгөх, шууд ярилцлагад орох, “Өнөөдөр”, “Үндэсний шуудан” сонин тус бүрд “Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх” төслийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхээр болов” гэсэн материалыг

нийтлүүлэх зэргээр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн түгээх замаар олон нийтэд даатгалын шинэ бүтээгдэхүүний талаарх мэдээлэл өгч, сурталчлах ажлыг зохион байгууллаа. Мөн “Монгол ньюс” төвд хэвлэлийн бага хурал зохион байгуулж, Монголын хэвлэлийн хүрээлэнгийн хамтын ажиллагаатай хэвлэл мэдээллийн 16 байгууллагад “Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх” төсөл, түүний хэрэгжилт, даатгалын зах зээлд гэр, хашаа, байшингийн бичил даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтэрч байгаа тухай болон цаашид уг төслийг хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдээлэл өгч ажиллалаа Холбооны нийт ажилтнуудын даатгалын талаарх мэдлэгийг гүнзгийрүүлж, Жолоочийн даатгалын тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлэх ажлын чадвар, дадлыг сайжруулах, бичил даатгалын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах чадавхийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болсон арга хэмжээ болж өндөрлөлөө.

СЗХ-оос “Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх” төслийн Дорнод, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл аймаг болон Хан-Уул, Налайх дүүргүүд дэх Даатгалын мэдээллийн төвүүдийн үйл ажиллагааг цаашид тогтвортой үргэлжлүүлэхээр тогтсон бөгөөд Албан журмын даатгагчдын холбоо нь Даатгалын тухай хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд уг төслийн Даатгалын мэдээллийн төвүүдээр дамжуулан хэрэгжүүлж байсан олон нийтийн даатгалын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиг үүргийг Холбооны төв, орон нутаг дахь салбар, нэгжүүдээр цаашид тогтвортой хэрэгжүүлэхээр тогтов.

Монгол улсад даатгалын салбар үүсч хөгжисний 80 жилийн ойг угтаж даатгалын салбарын үүсэл хөгжил, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд, цаашдын зорилт, даатгалын үйлчилгээ иргэд даатгуулагчдад хэрхэн хүрч байгааг олон нийтэд хүргэх зорилгоор СЗХ, Холбооны гишүүн даатгалын компаниуд, мэргэжлийн холбоод, даатгалын мэргэжлийн оролцогч нарыг оролцуулан TV5 телевизийн “Топ сэдэв”, “Eagle” ТВ-ийн “9:1” зэрэг 2 удаагийн хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулав.

2.5 ДААТГАГЧДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЯЛДААГ ХАНГАХ, АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ НЬ МАНАЙ ХОЛБООНЫ НЭГ ҮҮРЭГ ГЭЖ ҮЗЭЖ АЖИЛЛАЛАА.

Даатгагчдын санхүүгийн чадавхийг сайжруулахыг эрмэлзэж жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.1-д заасан даатгагчидаас төвлөрүүлэх хөрөнгийг тухай жилийн хураамжийн нийт дүнгээс бус тухайн оны орлогод тооцсон хураамжийн орлогоос 3%-иар тооцохоор байхаар Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан шийдвэр гаргуулж даатгагчдын үйл ажиллагааны зардлыг 100.0 сая орчим төгрөгөөр хямдруулав.

Даатгагч нарт жолоочийн даатгалын гэрээ хийх нөхөн төлбөр олгох, лавлагаа авах үйл ажиллагааг хөнгөвчилж онлайн програм хангамж бүхий МИИС систем боловсруулж үнэ төлбөргүй олгов. МИИС системийн сургалтыг ч үнэ төлбөргүй хийсэн болно. Мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэхтэй холбогдуулан даатгагч нарт зааж зааварлах, мэдээллийн алдааг тухай бүр засварлуулж ажилласнаар үнэн зөв чанартай мэдээлэл төвлөрүүлэх боломжийг бий болголоо.

Даатгалын гэрээний баталгааны наалтыг хэвлүүлэхэд жилд 100.0 сая төгрөгийн зардал гарч байсныг хэмнэж дээрх МИИС систем нэвтрүүлсэнийг ашиглаж даатгалын гэрээний дугаараар баталгаажуулж аливаа эрсдлийг нь хаах олон талын хүндрэлийг арилгах боломжийг бүрдүүлэв.

Даатгалын компаниудын зардлыг хэмнэх зорилгоор Орон нутаг дахь салбар нь шуурхай алба ажиллуулах боломжгүй тохиолдолд салбаруудад шуурхай албаны үйлчилгээг үзүүлэх гэрээ байгуулж 2014 онд 794 дуудлага хүлээн авч үйлчлэв. Шуурхай албаны дуудлагаас гадна хууль зүйн зөвлөгөө авах, мэдээлэл авахаар 6849 удаа хандсан байна.

Жолоочийн даатгалын ач холбогдлыг орон нутагт сурталчлахад нийтдээ 73.2 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг системтэй зохион байгуулж даатгагч, зуучлагч нартай хамтран ажилласнаар жолоочийн даатгалд хамрагдалтыг 86.000-аар нэмэгдүүлж хураамжийн хэмжээг 2.0 тэрбум орчим төгрөгөөр өсөв.

Хяналт шалгалтын ажлыг нийслэл, аймгийн замын цагдаагийн тасагтай хамтран 160 удаагийн шалгалт зохион байгуулж 64.8 мянган тээврийн хэрэгсэл хамруулж 12.191 зөрчил илрүүлж даатгалд хамруулжээ. Ийм хяналт шалгалт хийхдээ даатгагч, зуучлагч нарыг газар дээр нь ажиллуулж даатгал хийлгэх, торгох ажлыг нийт нутаг дэвсгэрийг хамарч зохион байгуулсан зохих үр дүнгээ өгч байсан болно. Энд даатгагч, зуучлагч нарыг татан оролцуулж байсан нь үйлчилгээг даатгуулагч нарт ойртуулаа. Та бидний хамтын ажиллагааны үр дүнд жолоочийн даатгалыг олон нийтэд нээлттэй болгож чадлаа.

Орон нутгийн даатгалын компаний салбарын мэдээллийн хурдыг шалгаж зааварчилгаа өгсөн нь МИИС систем ашиглах боломжийг сайжруулаа. Энэ бүхний үр дүнд жолоочийн даатгалын тухай иргэдийн мэдлэг мэдээлэл эрс сайжирч нийт даатгалын салбарын хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан гэж дүгнэж байна.

Даатгуулагч, хохирогчдын эрх ашгийг хамгаалах чиглэлд хэд хэдэн ажил хийв. Юуны өмнө нөхөн төлбөр олгох зааврыг аль болох чирэгдэлгүй болгож нэмэлт өөрчлөлт оруулсанаар хохиролоо нөхүүлэх боломж нэмэгдсэнийг тайлангаас харж болно. Хохиролоо нөхүүлэх бичиг баримт бүрдүүлэх хугацааг 30 хоногт багтаах шаардлага тавьж байсныг хязгаарлалтгүй болгов. Жолоочийн даатгалын талаар гарын авлага материал хэвлүүлэх, олон нийтийн арга хэмжээний үеэр тараах хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан сурталчилгаа хийв. Сурталчилгааны материалд хохирогч танд хэрхэн тусалж болох булан нээж ажилуулж байна.

Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахын тулд даатгуулагч өөрөө хяналт тавих автодорцов апплейкешнийг боловсруулж нэвтрүүлэв. Даатгуулагчид зориулсан мэдээллийн үр дүнд Даатгалын гэрээ хийхэд тодорхой мэдээлэлтэй болж даатгуулагчийн хийсэн гэрээ нь мэдээллийн нэгдсэн санд орж баталгаажсан эсэхийг өөрөө хянах боломж бүрдсэн болно. Даатгуулагч нөхөн төлбөрийн мэдээлэл, итгэлцүүрийн холбогдох мэдээлэлийг урьдчилан олж танилцах, улмаар жолоочийн даатгалын гэрээ хийх сэтгэл зүйн бэлтгэл хангагдсан байхаар зохион байгуулж өгсөн болно.

2.6 АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХОЛБООНЫ ДОТООД АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ САЙН БАЙХ ЁСТОЙ.

1. ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ ТАЛААР:

Тайлант хугацаанд тус Холбооны 2014-2016 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөө, 2014 оны Ажлын албаны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан даатгагч, хохирогчийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн үйлчилгээг нэвтрүүлэх Холбооны үйл ажиллагаанд мөрдөх хууль, эрх зүйн актад өөрчлөлт оруулах, санал боловсруулах, холбогдох судалгаа хийх, дүгнэлт бэлтгэх зорилтуудыг удирдлага болгон дараах ажлууд хийгдлээ. Тухайлбал,

Холбооны үйл ажиллагаатай холбогдох эрх зүйн актын санг бий болгох зорилгоор Монгол Улсын хууль, Улсын их хурлын тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны бусад яам, агентлагтай хамтран баталсан шийдвэр, АЖДХ-ны шийдвэр болон

бусад байгуулагатай байгуулсан гэрээ, санамж бичиг, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг товъёоглон хүснэгтилж гаргасан.

Одоогийн үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын төлөв байдалд судалгаа хийж өөрчлөлт оруулах шаардлагатай эрхийн актын жагсаалтыг Даатгалын сан, Мэдээллийн сан, Захиргааны хэлтэс, Сургалт, судалгаа, сурталчилгааны хэлтэс, АЖДХ-ны орон нутаг дахь салбаруудын санал авч нэгтгэсэн болно.

Дээр дурдсан дүн шинжилгээний дүнд илэрсэн давхардал, хийдэл, зөрчлийг арилган, дүрэм, журамд тусгагдсан зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах зорилгоор тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн төслийг танилцуулгын хамт боловсруулан Санхүүгийн зохицуулах хороо болон Холбооны Удирдах Зөвлөлд танилцуулаад байна.

Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор батлагдан гарсан журам, зааварт нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулан хүргүүлсэн. Үүнд:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 сарын 23-ны өдрийн 332 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний стандарт загвар”
2. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 сарын 23-ны өдрийн 334 дүгээр тогтоолоор батлагдсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний даатгуулагчийн мэдүүлгийн маягт”
3. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 сарын 26-ны өдрийн 378 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам”
4. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 сарын 26-ны өдрийн 393 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар”
5. Удирдах зөвлөлийн 2013 оны 02 тоот тогтоолоор мэдээллийн сангаас лавлагаа, мэдээлэл олгох, ашиглах журам батлагдсан бөгөөд тус журмаар нууцын баталгааг гаргуулдаг. Энэ нууцын баталгааг гаргуулдаг. Энэ нууцын баталгааг гар утасны шинэ үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбогдож даатгалын компаний ажилтан, мөн банкны бүх салбарын ажилтнууд, төлөөлөгчид, мөн даатгалын зуучлагчид, авто тээврийн төвийн ажилтнууд замын цагдаа нар хүн тус бүрээр гаргах болсон учраас хувь хүний болон байгууллагын нууцтай холбоотой асуудлыг тухайн байгуулагатай байгуулах гэрээний заалт болгож зохицуулахаар журамд өөрчлөлт орууллаа.
6. Мэдээллийн сангийн журам, даатгалын баталгааны наалт ашиглах журам, даатгалын гэрээний маягтын журамд өөрчлөлт оруулах талаар хамтарч ажиллаж төсөл боловсруулж СЗХ-нд хүргүүлэв.
7. МИИС системээр мэдээллийн санг төлбөртэй ашиглуулах талаар холбогдох судалгаа, төсөл боловсруулж удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулав.

Хамтран ажиллах чиг үүрэг бүхий байгууллагуудтай санамж бичиг, гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнд :

- Үндэсний дата төвийн хамтын ажиллагааны гэрээ байгуулж мэдээллийн санг зохих журмын дагуу төрийн байгууллагуудтай холболт хийх, мэдээлэл солилцох эрх зүйн орчинг бүрдүүлээ.
- Авто тээврийн төвтэй даатгалын хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан тээврийн хэрэгслийн оношилгоонд даатгалын мэдээллийг шалгаж байхаар болов.
- Нийслэлийн мэдээллийн технологийн төвтэй хамтран даатгуулагчдад өөрийн даатгалын мэдээллээ мэдээллийн санд үнэн зөв орсон эсэхэд хяналт тавих боломж олгох хамтын ажиллагааны гэрээ байгуулав.
- МИИС системийг ашиглуулах гэрээг боловсруулж холбогдох байгууллагуудтай хамтран мөрдөж байна.

2 Холбооны үйл ажиллагааны санхүүжилт, бүртгэл тооцооны талаар

Холбооны 2014 оны зардлын төсвийн төслийг Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулиудын удирдлага зарчим, хууль журмаар тогтоосон тусгай шаардлагууд, Жолоочийн даатгалын тухай хууль, Даатгалын тухай хууль, Албан журмын даатгагчдын холбооны дүрэм, Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журамд нийцүүлэн ирэх оны эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан орлогыг бодитой төлөвлөх, урсгал зардлын өсөлтийг хязгаарлах, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан боловсруулсан. Энэ зарчмыг баримталж Удирдах зөвлөл 2014 оны зардлыг төсвийг хуулийн хүрээнд баталж өгсөн юм.

Албан журмын даатгагчдын холбооны хэрэгжүүлэх үйл ажиллагааг болон үүргийг даатгалын тухай хуулийн 12.1.3, 12.1.5-д тодорхой заасан учир тухайн жилийн зардлыг жолоочийн даатгалын тухай хуулийн 23.1-д заасан зориулалтаар төлөвлөж, зарцуулж байна.

Холбооны 2014 оны үндсэн үйл ажиллагааны зардалд 1,246,518.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 480,887.5 мянган төгрөг төсөвлөсөн. Холбооны 2012 оноос хойшхи зардлын төсөв, 2014 оны зардлын гүйцэтгэлийн мэдээг хүснэгт №17-д дэлгэрэнгүй харуулав.

2014 оны үндсэн үйл ажиллагааны төлөвлөгдсөн зардлыг 284.6 сая төгрөгөөр хэмнэж нийт 961,870.3 мянган төгрөг зарцуулсан нь нийт даатгалын санд болон холбооны хөрөнгийн эх үүсвэрээр төвлөрүүлсэн нийт орлогын 27.67 хувьтай тэнцэж байна. Даатгалын санд хөрөнгө болж бэлтгэгдсэн хөрөнгө 1326 хувийг эзэлж байна.

Хүснэгт №20. АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭ /мян.төгрөгөөр/

д/д	Зардлын зүйл, төрөл	2012 оны гүйцэтгэл	2013 оны гүйцэтгэл	2014 оны батлагдсан төлөвлөгөө	2014 оны гүйцэтгэл
1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ					
1.1	Ажилтнуудын цалин, хөлс	167,014.3	298,502.2	601,753.0	488,431.8
1.2	Нийгмийн даатгалын шимтгэл /ажил олгогчоос төлөх/	17,836.5	31,305.2	66,192.8	51,350.8
1.3	Удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн урамшуулал	26,600.0	17,254.7	58,800.0	24,976.9
1.4	Томилолтын зардал	9,539.6	12,035.1	28,800.0	29,294.1
1.5	Захиргаа, аж ахуйн зардал	17,460.2	15,426.0	31,811.0	19,317.2
Үүнээс:	- Аж ахуйн зардал	6,586.7	11,088.4	3,675.0	731.9
	- Бичиг хэргийн зардал	3,681.9	4,337.6	10,880.0	10,880.0
	- Даатгал, оношлогоо, татвар	7,191.6	0,00	17,256.0	7,705.3
1.6	Оффисын байр, гражийн түрээсийн зардал	20,829.5	157,523.5	221,421.6	186,345.9
1.7	Шатахуун, сэлбэг, засварын зардал	10,039.7	11,674.9	92,913.6	52,246.3
1.8	Харилцаа холбооны зардал	7,487.7	15,981.5	30,326.0	27,643.6
1.9	Зар сурталчилгааны зардал	21,348.2	67,075.6	87,500.0	73,178.4
1.10	Зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалтын зардал	153.1	8,218.4	24,500.0	5,711.0

1.11	Даатгалын тохиолдлыг шалгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хохирол үнэлгээний зардал	0,00	598.0	2,500.0	3,374.3
1.12	Орон нутгийн салбаруудын урсгал зардал	0,00	6,480.3	0,00	0,00
Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн		298,308.8	642,075.4	1,246,518.0	961,870.3
2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ					
2.1	Тавилга, техник хэрэгсэл	26,701.9	55,245.9	38,989.5	35,942.7
2.2	Мэдээллийн сангийн програм хангамж, хөгжүүлэлтийн зардал	10,200.0	140,264.2	103,520.0	79,955.0
2.3	Ажлын алба, орон нутгийн шуурхай албадын автомашин худалдан авалт	0,00	190,000.0	338,378.0	338,320.0
2.4	Сургалтын техник, тоног төхөөрөмж	0,00	19,000.0	0,00	0,00
Хөрөнгө оруулалтын зардлын дүн		36,901.9	404,510.1	487,887.5	454,217.7
Нийт зардлын дүн		335,210.7	1,070,327.5	1,727,405.5	1,416,088.0

2014 оны 12 сарын 31 ний өдрийн байдлаар Холбооны нийт хөрөнгө 4,684,605.0 мян.төгрөг, үүнээс мөнгөн хөрөнгө 3,729,703.8 мян.төгрөг, авлага 121,383.0 мян.төгрөг /буцаан нэхэмжлэлтэй нөхөн төлбөрийн авлага 120,937.6/, эргэлтийн хөрөнгө /бараа материал/ 3,994.3 мян.төгрөг, үндсэн хөрөнгө элэгдэл хассан цэвэр дүнгээр 758,537.3 мянган төгрөг, биет бус хөрнгө /Мэдээллийн сангийн програм хангамж/ 70,986.6 мян.төгрөг тус тус байна.

Хүснэгт №21. Холбооны 2014 оны жилийн эцсийн санхүүгийн хураангуй тайлан

Балансын зүйл	2013.12.31		Гүйлгээ		2014.12.31	
	Дт	Кт	Дт	Кт	Дт	Кт
Мөнгөн хөрөнгө	1,819,655.4	0,00	6,956,388.1	5,046,339.8	3,729,703.8	-
Авлага	32,039.9	0,00	277,789.8	188,446.7	121,383.0	-
Бараа материал	14,081.2	0,00	7,043.0	17,129.9	3,994.3	-
УТЗ тооцоо	0,00	0,00	35,686.2	35,686.2	0,00	-
Үндсэн хөрөнгө	396,348.4	0,00	362,189.0	-	758,537.3	-
Биет бус хөрөнгө /програм хангамж/	49,300.0	0,00	21,686.6	-	70,986.6	-
Богино хугацаат өглөг	-	5,100.00	827,220.5	823,346.2	-	1,225.7
Нөөц сан	-	2,306,324.9	-	-	-	4,683,379.3
Хуримтлагдсан үр дүн	-	-	-	2,377,054.4	-	-
БАЛАНС	2,311,424.9	2,311,424.9	8,488,003.2	8,488,003.2	4,684,605.0	4,684,605.0

2015 оны санхүүгийн тайлан, бусад хавсралт тайлан мэдээг цаг алдалгүй гаргах боломжийг бий болгов.

2014 онд санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр дараах арга хэмжээнүүд авлаа.

- “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж Холбооны удирдах зөвлөлийн 2014 оны 12 сарын 04-ний өдрийн 14 тоот тогтоолоор батлууллаа.
 - Албан журмын даатгагчдын холбооны санхүүгийн нэмэлт тайлангийн хавсралт маягтуудын төслийг хорооны албан журмын болон амьдралын даатгалын хэлтсийн дарга П.Ууганбаяртай хамтран боловсруулж Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 01 сарын 14-ний өдрийн 07 тоот тогтоолоор батлууллаа.
 - Холбооны өдөр тутмын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг түргэн шуурхай, цаг алдалгүй хяналт тавьж зохион байгуулах зорилгоор “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний Leader 3.0 програмыг өөрийн онцлогт тохируулан хөгжүүлж 2015 оны 01 сарын 01-ний өдрөөс ашиглаж эхэллээ.
- Холбооны дотоод үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах зорилгоор бусад байгууллага /Петровис карт ХХК/-ын онлайн програмын эрхийг авч ажиллаж байна. Тухайлбал орон нутгийн салбаруудын шатахууны картын гүйлгээнд тухай бүр хяналт тавьж ажиллах, ажилтнуудын цагийн бүртгэлийг онлайнгаар бүртгэх зэрэг боломжийг бий болгоод байна.

3. Гадаад хамтын ажиллагааны талаар

Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу бусад улс орны ажлын туршлага судлах, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхааран ажиллаа. ОХУ-ын автодаатгагчдын холбооны ерөнхийлөгчийн урилгаар гүйцэтгэх захирал, даатгалын сангийн захиралын хамт айлчилж, хоёр талын хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа. Санамж бичигт тусгагдсаны дагуу ОХУ-ын автодаатгагчдын холбооны үйл ажиллагааны талаар байнгын мэдээлэл авч, страховая газета сэтгүүлд монголын албан журмын даатгалын талаар 2 удаа мэдээлэл тавигдлаа. Одоо байнгын холбоотой ажиллаж байна. Тайваны Тайпэй хотод болсон Азийн улс орны Автодаатгагчдын ээлжит хуралд Удирдах зөвлөлийн дарга Г.Хэрлэн, СЗХ-ны ердийн даатгалын хэлтсийн дарга Б.Жавхлант, Холбооны гүйцэтгэх захирал Д.Цэвээнжав нар оролцлоо. Цаашид энэ арга хэмжээнд монголын талаас оролцож байх нь ач холбогдолтой болохыг тэмдэглэж байна.

Энэ хурлын үеэр Солонгос улсын даатгалын хөгжлийн институтын удирдлагууд уулзалт хийж хамтран ажиллах санамж бичиг байгуулж ажиллахаар тохиролцов. 2014 оны Солонгос улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллагын зардлаар ажиллагааны байгууллагын зардлаар зөвлөх мэргэжилтэн ажиллуулж мэдээллийн сангийн цахим системийг сайжруулах тухай дүгнэлт гаргуулж авлаа. 2015 онд ч Солонгосын даатгалын хөгжлийн институт, Солонгос улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран ажиллах саналтай байна.

ГУРАВ: ДҮГНЭЛТ, САНАЛ

2014 оны ажлыг нэгтгэж дүгнэвэл байгаа хүний нөөцийг дээд зэргээр шавхаж санхүүгийн боломжийг ашиглаж жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлж байна. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тогтолцоо нэвтэрснээр тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, даатгалтай эсэхээс үл хамааран авто замын осолд өртсөн гуравдагч этгээд буюу эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэд, байгууллагад нөхөн төлбөр олгож, хариуцлагын даатгалын ач холбогдлыг ойлгуулж чадлаа.

Хууль хэрэгжиж эхэлсэн өнгөрсөн хугацаанд манай иргэд даатгалын талаар ерөнхий ойлголттой болж, жолоочийн хариуцлагын даатгалын ач холбогдлыг танин мэдэж байгаа боловч иргэдэд мэдээ,

мэдээллийг илүү ойртуулах, даатгалын ашиг тус, ач холбогдлыг гүнзгий таниулах, даатгалын зах зээлийг хөгжүүлэх талаар хийх ажил багагүй байгааг дурьдах нь зүйтэй. 2014 онд багагүй ажлыг амжуулсан боловч, цаашид анхаарах шийдвэрлэх тулгамдсан асуудлууд байсаар байна. Үүнд:

-Жолоочийн даатгалын гэрээ байгуулах, нөхөн төлбөр олгохын тулд мэдээллийн хүчирхэг бааз санг бий болгох, мэдээллийн чанарт онцгой анхаарах шаардлагатай байна. Үүний тулд мэдээллийн сангийн програм хангамж, сүлжээг шаардлагын түвшинд хүртэл яаралтай хөгжүүлэх, түүнд зориулж тодорхой төсөл боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй. Энэ асуудлыг зөвхөн Холбооны түвшинд бус Санхүүгийн зохицуулах хороогоор дамжуулан Засгийн газрын түвшинд танилцуулах, шийдвэрлүүлэх нь зүйтэй байна. Энэ чиглэлээр ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна. Аль ч салбарын үйл ажиллагааг оновчтой удирдахад цаг үеийн үнэн зөв мэдээлэл чухал үүрэгтэй. Иймд жолоочийн даатгалын санг түшиглэн даатгалын салбарын мэдээллийн нэгдсэн бааз бий болгох хэрэгцээ байгааг анхаарч бидний саналд дэмжлэг үзүүлнэ үү.

-Даатгалын сангийн орлогын бүрдүүлэлтийг УИХ-аас баталсан хуваарьт хугацаанд төвлөрүүлдэг болгох шаардлагатай байна. Сангийн сайд, Зам, тээврийн сайдын 2013 оны 20/19 тоот хамтарсан тушаалаар “Жолоочийн даатгалын сангийн дансанд хөрөнгө шилжүүлэх тухай” журмыг баталсан. Энэ журмын дагуу Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нар аймаг, нийслэлийн төсвийн хуваарьт тусгагдсан эх үүсвэрийн гүйцэтгэлийг сар тутам тооцож, дараа сарын 10-ны өдрийн дотор Албан журмын даатгагчдын холбооны жолоочийн даатгалын сангийн төвлөрсөн харилцах дансанд шилжүүлнэ” гэж заасан боловч хугацаандаа төвлөрүүлэхгүй байх хүндрэлүүд гарсаар байна. Мөн зам, тээврийн ослоос сэргийлэх зорилгоор ашиглагдах ёстой “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 28.1-д заасан торгуулийн орлогын 50 хувийг жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх эрхзүйн орчин төдийлөн сайн бүрдээгүй байна. Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх тухай эрх зүйн зохицуулалт байгаа хэдий ч төсөвт суулгаж батлагдаагүй гэсэн шалтгаанаар орон нутагт хэрэгжихгүй байна. Энэ нь Аймаг, нийслэлийн ИТХ-аас төсөв батлахдаа торгуулын орлогыг тооцон төлөвлөдөггүйтэй холбоотой байж болох юм. Энэ торгуулийн орлогыг Холбооноос нэхэмжилсэн баримтыг үндэслэн тухай бүр санхүүжүүлэх шаардлагатай байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 302 дугаар тогтоолоор баталсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ын 2 дугаар зүйл/ Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага/-ийн 2.5-д “Жолоочийн даатгалын тохиолдлыг шалгах шуурхай албатай байх” гэсэн заалтыг даатгалын компаниуд болон түүний салбарууд хэрэгжүүлэх үүрэгтэй. Гэтэл даатгалын компаниудад баримтлах эрх зүйн зохицуулалтгүй байгаагаас үйл ажиллагаа нь жигд бус, даатгалын тохиолдлын дуудлага хүлээж авах, үзлэг хийх ажиллагаа нь харилцан адилгүй, даатгалын тохиолдлын мэдээлэл мэдээллийн санд тухай бүр оруулахгүйн улмаас нөхөн төлбөрийн мэдээлэл ч нэгдсэн санд тухай бүр оруулахгүй байгаа дутагдлыг даатгагч нар гаргахгүй байхтай холбогдсон арга хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо яаралтай авах шаардлагатай байгааг анхаарна уу.

ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН БИЧСЭН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д. ЦЭВЭЭНЖАВ

ХАЯГ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо
6-р хороолол, Их тойруу 68/1 “ЛОГОС” төв 7 давхар
Албан журмын даатгагчдын холбоо

УТАС

+ (976) 7010-1177, 7012-1177, 7000-1040, 7000-1277

ФАКС

+ (976) 7000-1040

ВЕБ ХАЯГ

www.ami.mn

ФЕЙСБҮҮК ХУУДАС

www.facebook.com/www.AMI.mn